

“БИЧИЛ УУРХАЙЧДЫН ОРОЛЦОО БА НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ”

ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН



“БИЧИЛ УУРХАЙЧДЫН ОРОЛЦОО БА
НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ”
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2017 он

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	5
Зургийн жагсаалт	6
Хүснэгтийн жагсаалт	8
Өмнөх үг	9
Тайлангийн хураангуй	11
Удиртгал	14
Судалгааны зорилго	14

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: Судалгааны арга зүй, зохион байгуулалт

1.1 Судалгааны арга зүй, асуулга	15
1.2 Түүврийн загвар	16
1.3 Судалгааны асуулга	16
1.4 Судалгааны зохион байгуулалт, мэдээлэл цуглуулах ажил	16
1.5 Мэдээлэл боловсруулалт болон үр дүнгийн шинжилгээ	17
1.5.1 Мэдээлэл шивэлтийн програм	17
1.5.2 Мэдээлэл шивэлт болон боловсруулалт	17
1.5.3 Үр дүнгийн шинжилгээ	18

ХОЁРДУГААР БҮЛЭГ: Судалгааны хамрагдалт ба хамрагдсан гишүүдийн шинж байдал

2.1 Судалгааны хамрагдалт	19
2.2 Судалгаанд хамрагдсан гишүүдийн шинж байдал	20

ГУРАВДУГААР БҮЛЭГ: Бичил уурхайн байгууллагуудын нөлөөллийн ажил, гишүүдийн оролцоо

3.1 БУБ-ын гишүүдийнхээ эрхийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж буй нөлөөллийн ажил, гарч буй өөрчлөлт	24
3.2 Бичил уурхайн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх нөлөөллийн ажил	28
3.3 Эрхээ шаардах, хамгаалах санаачлага, гишүүдийн оролцоо, гарч буй өөрчлөлт	30
3.3.1 Орон нутгийн захиргаанд илгээсэн хүсэлтийн тоо, төрөл	33
3.3.2 БУБ-ын удирдлагад гаргасан хүсэлтийн тоо, төрөл	34
3.3.3 УУКомпаний удирдлагад гаргасан хүсэлтийн тоо, төрөл	36
3.3.4 Бусад хүсэлтүүдийн талаар	37

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: БУБ-ын удирдлага ба гишүүдийн оролцоо

4.1 БУБ-ын байгууллагаас зохион байгуулж буй ажилд гишүүдийн оролцоо ба ялгаатай байдал, гарч буй өөрчлөлт	40
--	----

4.2.	Үйл ажиллагааны төрөл гишүүдийн оролцоо ба ялгаатай байдал, гарч буй өөрчлөлт	42
4.3.	БУБ-ын байгууллагаас зохион байгуулж буй ажилд гишүүд оролцож чаддаггүй шалтгаан гарч буй өөрчлөлт	44
4.4	Бүх гишүүдийн хурал ба гишүүдийн оролцоо, ялгаатай байдал, гарч буй өөрчлөлт	46
4.5.	БУБ-ын шийдвэр ба гишүүдийн оролцоо, гарч буй өөрчлөлт	48

ТАВДУГААР БҮЛЭГ: БУБ-ын гишүүдийн эрхийн тухай ойлголт, мэдлэгийн түвшин ба хэрэгжилтийн үнэлгээ

5.1.	Хөдөлмөрлөх эрх буюу олборлолтын газраар хангагдах эрхийн талаарх мэдлэг, гарч буй өөрчлөлт	52
5.2.	Хөдөлмөрлөх эрх буюу олборлолтын газраар хангагдах эрхийн хэрэгжилтийн үнэлгээ, гарч буй өөрчлөлт	54
5.3.	Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн талаарх мэдлэгийн түвшин гарч буй өөрчлөлт	56
5.4.	Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн хэрэгжилтийн үнэлгээ, гарч буй өөрчлөлт	58
5.5.	Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн талаарх мэдлэгийн түвшин, гарч буй өөрчлөлт	60
5.6.	Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн хэрэгжилтийн үнэлгээ, гарч буй өөрчлөлт	62

ЗУРГААДУГААР БҮЛЭГ: Судалгааны товч дүгнэлт, зөвлөмж

6.1.	Товч дүгнэлт	64
6.2.	Зөвлөмж	66

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АМГТГ	АШИГТ МАЛТМАЛ ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
БЗД	БАГИЙН ЗАСАГ ДАРГА
БИНХ	БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛ
БУБ	БИЧИЛ УУРХАЙН БАЙГУУЛЛАГА
БУ	БИЧИЛ УУРХАЙЧИН
ЗД	ЗАСАГ ДАРГА
ЗДТГ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
МБУНДХ	МОНГОЛЫН БИЧИЛ УУРХАЙН НЭГДСЭН ДЭЭВЭР ХОЛБОО
МСҮТ	МЭРГЭЖИЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, СУРГАЛТЫН ТӨВ
ИТХ	ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
ТБУТ	ТОГТВОРТОЙ БИЧИЛ УУРХАЙ ТӨСӨЛ
ТББ	ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА
УУК	УУЛ УУРХАЙН КОМПАНИ
ХАБ	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ
ХХҮГ	ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 2.1. Судалгаанд хамрагдсан гишүүдийн хувь, аймгаар, 2016 он
- Зураг 2.2. Судалгаанд хамрагдсан гишүүдийн хувь, хүйсээр, 2015, 2016 он
- Зураг 2.3. БУБ-ын нийт, сонгогдсон болон судалгаанд хамрагдсан гишүүдийн хувь, хүйсээр, 2016 он
- Зураг 2.4. Судалгаанд хамрагдсан гишүүдийн хувь насны бүлгээр, 2016 он
- Зураг 2.5. Судалгаанд хамрагдсан гишүүдийн хувь, боловсролоор, 2016 он
- Зураг 2.6. Судалгаанд хамрагдсан гишүүдийн тоо, хувь, ордын төрлөөр, 2016 он
- Зураг 3.1. Гишүүдээ төлөөлж гэрээ хэлцэл хийсэн байдал хувиар, 2015, 2016 он
- Зураг 3.2. Гишүүдээ төлөөлж гэрээ хэлцэл хийсэн байдал, хүйсээр, хувиар, 2015, 2016 он
- Зураг 3.3. Олон нийтийн хандлага сайжирсан гэж хариулсан гишүүдийн хувь, хүйсээр, 2015, 2016 он
- Зураг 3.4. Орон нутгийн иргэд, малчдаас шахалт, дарамт үзүүлж байгаа гэж хариулсан гишүүдийн хувь, хүйсээр, 2015, 2016 он
- Зураг 3.5. Албан хүсэлтийн хувь, гаргасан байгууллагаар, 2015, 2016 он
- Зураг 3.6. Албан хүсэлтийн хувь, гаргасан байгууллагаар, хүйсээр, 2015, 2016 он
- Зураг 3.7. Орон нутгийн захиргаанд гаргасан албан хүсэлтийн тоо, төрөл, 2015, 2016 он
- Зураг 3.8. БУБ-ын удирдлагад гаргасан албан хүсэлтийн тоо, төрөл, 2015, 2016 он
- Зураг 3.9. УУК-ний удирдлагад гаргасан албан хүсэлтийн тоо, хүйсээр, 2015, 2016 он
- Зураг 4.1. БУБ-аас зохион байгуулж байгаа ажилд гишүүдийн оролцож буй байдал, хувиар, 2015, 2016 он
- Зураг 4.2. БУБ-аас зохион байгуулж байгаа ажилд гишүүдийн оролцож буй байдал, хувиар, хүйсээр, 2015, 2016 он
- Зураг 4.3. БУБ-аас зохион байгуулж байгаа ажилд гишүүдийн оролцож буй байдал, хувиар, ажлын төрлөөр, 2015, 2016 он
- Зураг 4.4. БУБ-аас зохион байгуулж буй ажилд оролцож чаддаггүй шалтгаан, хувиар, 2015, 2016 он
- Зураг 4.5. БУБ-аас зохион байгуулж буй ажилд оролцож чаддаггүй шалтгаан, хувиар, хүйсээр, 2015, 2016 он
- Зураг 4.6. Бүх гишүүдийн хуралд оролцож байгаа байдал, хувиар, 2015, 2016 он
- Зураг 4.7. Бүх гишүүдийн хуралд оролцож байгаа байдал, хувиар, хүйсээр, 2015, 2016 он
- Зураг 4.8. Бүх гишүүдийн хуралд оролцож чадахгүй байгаа шалтгаан, хувиар, 2015, 2016 он
- Зураг 4.9. Бүх гишүүдийн хуралд оролцож чадахгүй байгаа шалтгаан, хувиар, хүйсээр, 2015, 2016 он
- Зураг 4.10. БУБ-ын удирдлагын зүгээс гаргаж буй шийдвэрт оролцож буй байдал, хувиар, 2015, 2016 он

- Зураг 4.11. БУБ-ын удирдлагын зүгээс гаргаж буй шийдвэрт оролцож буй байдал, хувиар, хүйсээр, 2015, 2016 он
- Зураг 4.12. БУБ шийдвэрийг гаргаж буй байдал, хувиар, 2015, 2016 он
- Зураг 5.1. Хөдөлмөрлөх /олборлолтын газар/ эрхийн талаарх гишүүдийн мэдлэг, хувиар, 2015, 2016 он
- Зураг 5.2. Хөдөлмөрлөх /олборлолтын газар/ эрхийн талаарх гишүүдийн мэдлэг, хувиар, хүйсээр, 2015, 2016 он
- Зураг 5.3. Хөдөлмөрлөх /олборлолтын газар/ эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал, хувиар, 2015, 2016 он
- Зураг 5.4. Хөдөлмөрлөх /олборлолтын газар/ эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал, хувиар, хүйсээр, 2015, 2016 он
- Зураг 5.5. Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн талаарх гишүүдийн мэдлэг, хувиар, 2015, 2016 он
- Зураг 5.6. Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал, хувиар, 2015, 2016 он
- Зураг 5.7. Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн талаарх гишүүдийн мэдлэг, хувиар, 2015, 2016 он
- Зураг 5.8. Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал, хувиар, 2015, 2016 он

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 3.1. Гишүүдээ төлөөлж БУБ-ын удирдлагаас албан хүсэлт гаргаж буй байдал, 2016 он
- Хүснэгт 3.2. Албан хүсэлтийн хувь, гаргасан байгууллагаар, насны бүлгээр, боловсролоор, 2015, 2016 он
- Хүснэгт 3.3. Орон нутгийн удирдлагад гаргасан албан хүсэлтийн тоо, төрлөөр, нас, хүйс, боловсролоор, 2015, 2016 он
- Хүснэгт 3.4. БУБ-ын удирдлагад гаргасан хүсэлтийн тоо, төрлөөр, нас, хүйс, боловсролоор, 2015, 2016 он
- Хүснэгт 3.5. УУКомпанид гаргасан албан хүсэлтийн тоо, нас, хүйс, боловсролоор, 2015, 2016 он
- Хүснэгт 3.6. 2016 онд шинээр гаргасан хүсэлтийн тоо, төрлөөр, байгууллагаар
- Хүснэгт 4.1. БУБ-аас зохион байгуулж байгаа ажилд гишүүдийн оролцож чаддаг эсэх, хувиар, насны бүлгээр, боловсролоор, 2015, 2016 он
- Хүснэгт 4.2. БУБ-аас зохион байгуулж байгаа ажилд гишүүдийн оролцож буй байдал, хувиар, ажлын төрлөөр, хүйсээр, 2015, 2016 он
- Хүснэгт 4.3. БУБ-аас зохион байгуулж байгаа ажилд гишүүдийн оролцож буй байдал, хувиар, ажлын төрлөөр, насны бүлгээр, 2015, 2016 он
- Хүснэгт 4.4. БУБ-аас зохион байгуулж буй ажилд оролцож чаддаггүй шалтгаан, хувиар, насны бүлгээр, боловсролоор, 2015, 2016 он
- Хүснэгт 4.5. БУБ шийдвэрийг гаргаж буй байдал, хувиар, хүйсээр, 2015, 2016 он
- Хүснэгт 5.1. Хөдөлмөрлөх /олборлолтын газар/ эрхийн талаарх гишүүдийн мэдлэг, хувиар, насны бүлэг, боловсролоор, 2015, 2016 он
- Хүснэгт 5.2. Хөдөлмөрлөх / олборлолтын газар/ эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал, хувиар, насны бүлгээр, боловсролоор, 2015, 2016 он
- Хүснэгт 5.3. Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн талаарх гишүүдийн мэдлэг, хувиар, хүйсээр, 2015, 2016 он
- Хүснэгт 5.4. Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн талаарх гишүүдийн мэдлэг, хувиар, насны бүлгээр, боловсролоор, 2015, 2016 он
- Хүснэгт 5.5. Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал, хувиар, хүйсээр, 2015, 2016 он
- Хүснэгт 5.6. Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал, хувиар, насны бүлгээр, боловсролоор, 2015, 2016 он
- Хүснэгт 5.7. Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн талаарх гишүүдийн мэдлэг, хувиар, хүйсээр, насны бүлгээр, боловсролоор, 2015, 2016 он
- Хүснэгт 5.8. Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал, хувиар, насны бүлгээр, боловсролоор, 2015, 2016 он
- Хүснэгт 5.9. Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал, хувиар, хүйсээр, 2015, 2016 он
- Хүснэгт 5.10. Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал, хувиар, хүйсээр, насны бүлгээр, боловсролоор, 2015, 2016 он

ӨМНӨХ ҮГ

Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төслийн 4-р үе шатны хөгжлийн зорилт нь “Эдийн засгийн хувьд тогтвортой, байгаль орчны хувьд хариуцлагатай, хүний эрхэд суурилсан Монгол Улсын бичил уурхайн салбар нь бичил уурхайн талаарх дэлхийн бусад орны сайн туршлагаас суралцан үр шимийг хүртэхийн хамт өөрөө хувь нэмэр оруулах” юм.

Энэ зорилтын хүрээнд төслийн зүгээс бичил уурхайчдын байгууллага болох нөхөрлөл, хоршоо, төрийн бус байгууллагуудын чадавхыг бүрдүүлэх, гишүүн бичил уурхайчдын эрхээ мэдэх, эрхээ нэхэмжлэх, аливаа үйл ажиллагаанд бүх гишүүдийн идэвхтэй, чөлөөтэй, тэгш оролцоог дээшлүүлэхэд шаардагдах мэдлэг, мэдээллийг хүргэх, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхэд нь төрөл бүрийн дэмжлэгийг үзүүлж ирлээ.

Бичил уурхайчид холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулалтад орж, газрын асуудлаа шийдвэрлүүлэн албажсанаар сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд тэдний амьжиргаа дээшилж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй сайжран улмаар орон нутгийн хөгжилд олон талаар хувь нэмрээ оруулж буй бодит жишээ, сайн туршлага, сургамжууд бичил уурхайчдын дунд ихээр бий болжээ.

Иймд Тогтвортой бичил уурхайн төслөөс бичил уурхайчдын 23 байгууллагыг сонгон авч тэдгээрийн гишүүдийн хүний эрхийн талаарх мэдлэгийн түвшин, эрхээ шаардах чадварт гарч буй өөрчлөлт, эрхээ хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлснээр өөрсдийн ажил амьдралдаа эерэг өөрчлөлтийг бий болгож чадаж буй эсэхийг 2015 онд хийгдсэн суурь судалгааны үр дүнтэй харьцуулсан судалгааг 2016 онд хийсэн юм.

Энэхүү харьцуулсан судалгаа нь асуулгын судалгааны аргаар хийгдсэн ба цаашид бичил уурхайн байгууллагуудын гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, эрхээ шаардах, үүргээ биелүүлэхэд анхаарах асуудлуудын талаар бичил уурхайн байгууллага, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо, Тогтвортой бичил уурхайн төсөлд холбогдох зөвлөмжүүдийг боловсруулсныг энэхүү тайланд тусгасан байна.

Тогтвортой бичил уурхайн төслөөс хамтран ажилладаг бичил уурхайн нөхөрлөл, хоршоо, ТББ-уудын гишүүдийн хүний эрхийн талаарх мэдлэг мэдээлэл, нөлөөллийн ажил хийх, эрхээ шаардах чадварыг нэмэгдүүлэхэд нь хувь нэмэр оруулах зорилгоор энэхүү харьцуулсан судалгааны тайланг хэвлүүлж байна.

Тогтвортой бичил уурхайн төслийн хэрэгжилтийн хүрээнд хүний эрхэд суурилсан арга барил, жендэрийн тэгш байдлын талаар хамтарч ажилласан бүх мэргэжлийн болон иргэний нийгмийн байгууллагууд, зөвлөхүүд болон бичил уурхайчиддаа төслийнхөө хамт олны өмнөөс талархал илэрхийлье.

Та бүхний цаашдын ажил, амьдралд хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Б.Алтанбагана

Тогтвортой бичил уурхай төслийн зохицуулагч

ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Монголд хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэх зорилго бүхий БУБ-ууд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулсаар нилээдгүй хугацаа өнгөрөөд байна. ТБУТ, хамтрагч байгууллагууд болон МБУНДХ-ноос бичил уурхайчдын байгууллагын чадавхыг бэхжүүлэх, хүний эрхэд суурилсан хандлагыг хөгжүүлэх, гишүүдийн оролцооны чадавхыг дээшлүүлэх, эрүүл аюулгүй нөхцөлд бүтээмжтэй, хариуцлагатай бичил уурхайг эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллаж ирсэн.

БУ-чид эрхээ мэдэх, шаардах, бичил уурхайн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг дээшлүүлэх зорилгоор хийж буй нөлөөллийн ажлын үр дүн, гарч буй өөрчлөлт, үр дүнг суурь судалгааны үетэй харьцуулан гаргасан.

Бичил уурхайчдын эрхийн талаарх мэдлэг, мэдээлэл нэмэгдсэнээр эрхээ шаардах, бичил уурхайн талаар олон нийтийн ойлголт мэдлэгийг сайжруулах талаар зохих үр дүнтэй ажлуудыг хэрэгжүүлсэн байна.

БУБ-ын удирдлагууд гишүүдийнхээ эрхийг хамгаалах зорилгоор холбогдох байгууллага, албан тушаалтанд хүсэлтээ албан ёсоор бичгээр илэрхийлэх, баримтжуулах чадвар суурь судалгааны үетэй харьцуулахад нэмэгдсэн байна. Бичил уурхайн байгууллагаас гишүүдээ төлөөлж эрхээ хамгаалах, хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилгоор нийт 107 хүсэлтийг байгууллага, албан тушаалтанд албан ёсоор бичгээр гаргасан байна.

Судалгаанд хамрагдсан гишүүдийн 28.8 хувь нь БУБ-ын удирдлага нь

гишүүдийнхээ эрхийг хамгаалах зорилгоор орон нутгийн захиргаатай, 31.6 хувь нь УУК-тай гэрээ хэлцэл хийх талаар санаачлага гарган ажиллаж байгаа гэж үздэг байна.

БУБ-уудаас орон нутагт явуулж буй нөлөөллийн ажлын нэг хэлбэр болох бичил уурхайн талаарх олон нийтийн хандлагыг өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласны дүнд иргэд, малчдын хандлага сайжирч байгаа гэж эрэгтэй гишүүдийн 53.7 хувь нь, эмэгтэй гишүүдийн 52.5 хувь нь үздэг байна.

Эрхээ шаардах, хангах зорилгоор нийт гишүүдийн 21.4 хувь орон нутгийн захиргаандаа, 16.8 хувь нь БУБ-ынхаа удирдлагад, 15.7 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулж буй УУК-д өөрийн албан хүсэлт гаргахад оролцож байсан гэжээ. 2015 оны суурь судалгааны үр дүнтэй харьцуулж үзвэл орон нутгийн захиргаандаа гаргаж байсан хүсэлт 13.8 пунктээр, БУБ-ынхаа удирдлагад гаргаж байсан хүсэлт 11.2 пунктээр, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй УУК-д гаргасан хүсэлт 14.6 пунктээр тус тус нэмэгдсэн байна. Бичил уурхайчид өөрийн хүсэлтээ сумын ИТХурал болон Засаг даргад хандаж гаргах нь нийтлэг байна.

Орон нутгийн удирдлагад хүсэлт гаргахад оролцсон эрэгтэйчүүд гишүүдийн хувь суурь судалгааны үеэс 15.2 пунктээр, эмэгтэйчүүдийн хувь 11.7 пунктээр тус тус нэмэгджээ.

БУБ-даа гаргасан хүсэлтийн тоог суурь онтой харьцуулж үзвэл эмэгтэйчүүд давамгайлж буй ба эрэгтэйчүүдээс 13.6 хувиар өндөр байна. Суурь судалгаанаас хойшх

хугацаанд УУК-д хандан хамтран ажиллах хүсэлт гаргахад оролцсон эрэгтэйчүүд 15.2 хувиар, эмэгтэйчүүд 13.7 хувиар тус тус нэмэгджээ.

Судалгааны үр дүнгээс харахад БУБ-аас хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд гишүүдийн 25.5 хувь нь оролцож чаддаг, 44.5 хувь нь хааяа оролцдог, 30.0 хувь нь оролцож чадахгүй байна гэж хариулжээ. Суурь судалгааны дүнтэй харьцуулж үзвэл оролцож чаддаггүй гишүүдийн хувь 8.8 пунктээр буурч тогтмол оролцож чаддаг гишүүдийн хувь 2.2 пунктээр, хааяа оролцдог гишүүдийн хувь 6.6 пунктээр тус тус өссөн нь гишүүдийн оролцоо, сонирхол дээшилж байгааг харуулж байна. Зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцож чаддаг эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийнхээс 3.0 пунктээр илүү өссөн байна.

Судалгаанд хамрагдсан гишүүдийн 85.0 хувь нь олборлолт хийхэд, 54.0 хувь нь бүх төрлийн сургалтанд оролцдог гэж хариулсан ба суурь судалгааны үес өссөн байна. “Мэдээлэл байдаггүй” гэж гэх шалтгаанаар БУБ-ын үйл ажиллагаанд оролцож чадахгүй байгаа гишүүдийн хувь 13.1 пунктээр буурсан байна. Энэ нь зарим БУБ-ын удирдлагаас зохих санаачлага гарган үйл ажиллагааны талаарх мэдээллийг гишүүдэд хүргэх ажил сайжирч байгаагийн дүнд ялангуяа эмэгтэйчүүд мэдээлэл авах боломж нэмэгдсэн байна.

БУБ-ын шийдвэр гаргах гол арга болсон бүх гишүүдийн хуралдоролцох оролцоо буурсан байна. Судалгаанд хамрагдсан гишүүдийн 23 хувь нь тогтмол 32.1 хувь нь хааяа, 35.4 хувь нь оролцож байгаагүй, 9.5 хувь

нь бүх гишүүдийн хурал хийдэггүй гэж хариулжээ. Суурь судалгаатай харьцуулж үзвэл тогтмол болон хааяа оролцдог гишүүдийн хувь 2.7 болон 8.2 пунктээр тус тус буурсан байна.

БУБ-аас гаргаж буй шийдвэрт гишүүдийн оролцоо буурсан байна. Судалгаанд хамрагдсан гишүүдийн 25.2 хувь нь шийдвэр гаргахад тогтмол, 35.9 хувь нь хааяа оролцдог, 38.9 хувь нь оролцож чаддаггүй гэжээ. Ихэнх гишүүд БУБ-ын тэргүүн, нөхөрлөлийн ахлагч нар л шийдвэр гаргадаг гэж үздэг байна.

УЗ тэргүүн хамтарч шийдвэр гаргадаг гэж үздэг гишүүдийн хувь 18.8 пунктээр нэмэгдсэн нь шийдвэрт УЗ-ийн оролцоо бага боловч нэмэгдэж буйг харуулж байна.

Ихэнх БУБ-ын удирдлагын санаачлага хангалтгүй, олборлолтын газаргүйгээс үйл ажиллагаа зогсонги болсон зэргээс шалтгаалан БУБ-ын гишүүн болсны давуу тал, боломжууд алдагдсанаар нөхөрлөлийн бүтцийг илүүд үзэх хандлагатай болсон байна. Тодруулбал нийт хариулагчдын бараг 1/4 хувь нь БУБ-ын гишүүн байсны “давуу тал байхгүй” гэж хариулсан байна.

Хэдийгээр гишүүдийн эрхийн талаарх мэдлэгийн түвшин сайжирч буй боловч хэрэгжилтийн байдалд өгсөн үнэлгээ буурсан байна. Суурь судалгаатай харьцуулбал хөдөлмөрлөх эрхийн талаарх сайн мэддэг гишүүдийн хувь 4.1 пунктээр нэмэгдэж, мэдэхгүй гишүүдийн хувь 12.2 пунктээр буурсан байна. Улмаар уг эрхийн хэрэгжилтийг судалгаанд хамрагдаж гишүүдийн 19.6 хувь нь сайн хэрэгждэг, 30.2 хувь нь огт хэрэгждэггүй гэж үнэлсэн байна. 2015 оны суурь судалгаатай харьцуулбал

огт хэрэгждэггүй гэсэн гишүүдийн хувь 5.6 пунктээр нэмэгджээ. БУБ-ын гишүүд олборлолтын газар байхгүй УУК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж чадаагүй зэрэг хүчин зүйлээс шалтгаалж хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн үнэлгээ буурах хандлагатай болсон байна.

Үнэн зөв мэдээллээр хангагдах

эрхийн талаарх мэддэггүй гишүүдийн хувь суурь судалгаа үеэс 10.2 пунктээр буурч мэдлэгийн түвшин нэмэгдсэн боловч сайн хэрэгждэг гэж үздэг гишүүдийн хувь 5.9 пунктээр буурч, огт хэрэгждэггүй гэж үздэг гишүүдийн хувь 4.8 пунктээр өссөнөөр хэрэгжилтийн үнэлгээ нь буурсан байна.



УДИРТГАЛ

Тогтвортой бичил уурхай төсөл нь БУ-г албан ёсны эдийн эдийн засагтай уялдуулах, БУ-аас хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэхийг зорин БУ-ын хууль эрх зүйн орчныг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, БУ-чдын чадавхыг бэхжүүлэх, хүний эрхэд суурилсан хандлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх замаар эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах чиглэлээр ихээхэн анхаарч ажиллаж ирсэн.

Тогтвортой бичил уурхай төслийн хүрээнд 2015 онд БУ-н нийт 23 байгууллагын гишүүдийг хамруулсан суурь судалгаа хийж БУБ-ын болон гишүүдийн эрхийн талаарх ойлголт, мэдлэг, эрхийн хэрэгжилтийг шаардаж байгаа байдал зэргийг судлан дүгнэсэн. Судалгааны үр дүнд гишүүдийн БУБ-ын удирдлага шийдвэр гаргах явцад оролцох, эрхээ шаардах, нөлөөллийн ажлыг сайжруулах зорилгоор санал зөвлөмжүүдийг боловсруулан БУ-чдын Зөвлөлдөх уулзалтанд танилцуулж улмаар БУБ-уудын чадавхыг бэхжүүлэх төрөл бүрийн үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн.

БУБ-ын удирдлагад гишүүдийн оролцоо, гишүүдээс эрхээ мэдэх, шаардах БУ талаарх олон нийтийн ойлголт хандлагыг дээшлүүлэх зорилгоор хийж буй нөлөөллийн ажлын үр дүн, гарч буй өөрчлөлт, үр дүнг тодорхойлох үүднээс харьцуулсан судалгааг хийхээр болсон. Харьцуулсан судалгааг хийснээр суурь судалгаанаас хойшх хугацаанд БУБ-ын шийдвэр гаргах үйл явц, эрхээ мэдэх, шаардах болон БУБ-ын нөлөөллийн үйл ажиллагаанд гишүүдийн оролцооны түвшин түүнд гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох боломжтой болох юм.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Судалгааны зорилго нь БУБ-ын гишүүдийн эрхийн талаарх мэдлэг, эрхээ шаардах нөлөөллийн ажлын үр дүн зэрэгт гарч буй өөрчлөлтийг 2015 оны суурь судалгааны үетэй харьцуулан тодорхойлоход оршино.



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АСУУЛГА

Судалгаанд мэдээлэл цуглуулах тоон болон чанарын аргуудыг хослуулан хэрэглэсэн. Тухайлбал, судалгаанд түүвэрлэгдсэн БУБ-ын гишүүдээс асуулгын судалгаа, БУБ-ын тэргүүн болон сонгогдсон зарим гишүүдтэй ганцаарчилсан ярилцлага хийх, холбогдох баримт бичигтэй танилцах, гэрэл зургаар баталгаажуулах

зэрэг мэдээлэл цуглуулах аргуудыг ашигласан болно. Түүнчлэн чадавх бэхжүүлэх сургалтын ач холбогдол гарч буй үр дүнг үнэлэхэд шаардагдах мэдээллийн матрицийг боловсруулж түүнд үндэслэн дүн шинжилгээ хийж судалгааны асуулгыг боловсруулахад ашигласан.

1.2 ТҮҮВРИЙН ЗАГВАР

Суурь судалгаанд хамрагдсан БУБ-уудыг тус судалгаанд сонгосон ба 6 аймгийн, 14 сумын 26 БУБ хамрагдсан юм. Судалгаанд хамрагдах гишүүдийг энгийн санамсаргүй түүврийн аргаар сонгосон бөгөөд түүврийн хэмжээ 560 болно. Ингэхдээ дараах үзүүлэлтүүдийг түлхүүр үзүүлэлтээр сонгон түүврийн хэмжээг тодорхойлж харьцуулсан юм. Үүнд: эрхээ шаардах албан хүсэлт гаргасан БУБ, гишүүдийн хувь; БУБ-ын үйл ажиллагаанд тогтмол оролцож

чаддаг гишүүдийн хувь; БУБ-ын шийдвэр гаргахад саналаа тусгаж чаддаг гишүүдийн хувь зэрэг болно. Сонгогдсон ТББ-ын бүх гишүүд түүврийн хүрээг бүрдүүлэх бөгөөд гишүүдээс санамсаргүй байдлаар сонголт хийсэн. Түүврийн хэмжээг тухайн ТББ-ын бүртгэлтэй гишүүдийн тооноос хамааран сонгогдсон 26 ТББ-дад пропорционалиар хуваарилсан болно. Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу.

1.3 СУДАЛГААНЫ АСУУЛГА

Асуулгын төслийг Си Эс Ди Зөвлөх багийн гишүүд бэлтгэж ТБУТөслийн ахлах эксперт Т.Энхцэцэг, эксперт

Д.Ганчимэг, Ө.Батсайхан нараас санал авч эцэслэн боловсруулсан.

Бичил уурхайчдын ТББ-ын гишүүдээс авах асуулга нь 5 бүлэг, 36 асуулттай. Үүнд:

Бүлэг 1: Ерөнхий мэдээлэл (4 Qs)

Бүлэг 2: ТББ-ын үйл ажиллагаанд гишүүдийн оролцоо (10 Qs)

Бүлэг 3: ТББ-ын нөлөөллийн ажил, гишүүдийн эрх ба тэгш бус байдал (12 Qs)

Бүлэг 4: ТББ-ын санхүүжилт ба гишүүдийн оролцоо (4 Qs)

1.4 СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АЖИЛ

Судалгааны баг нь ахлагч, 2 судлаач, дата бааз менежер нийт 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр судалгааны загвар, мэдээлэл цуглуулах болон боловсруулах ажлын даалгаврын дагуу судалгааны хэрэгжилтийг удирдан зохион байгуулж ажилласан. Судалгааны баг судалгаанд ашиглах

асуулга, мэдээлэл боловсруулах программын урьдчилсан шаардлага зэргийг ойлгох, асуулгыг хэрхэн бөглөх талаар багийн уулзалт хийж мэдээлэл цуглуулах ажлыг 2016 оны 2 сарын 15-аас 3 сарын 25 хооронд явуулсан.


1.5 МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ БОЛОН ҮР ДҮНГИЙН ШИНЖИЛГЭЭ

1.5.1 Мэдээлэл шивэлтийн програм

Мэдээлэл шивэлтийг PASW Statistics 18.0 (SPSS) програмыг ашиглан гүйцэтгэсэн ба мэдээлэл шивэлтийн програмыг судалгааны асуулгын дагуу боловсруулсан.

Өөрөөр хэлбэл, асуулгын бүтэц буюу олон сонголттой болон бусад гэсэн

нэмэлт хариултуудаас хамаарсан 165 хувьсагчтай шивэлтийн мэдээллийн санг үүсгэсэн ба асуулга бүр 1 мэдээллийн нэгж буюу нийт 560 нэгж бүхий мэдээллийн санг үүсгэж байгаа юм.



	Name	Type	Width	Decimals	Label	Values	Missing	Columns	Align	Measure	Role
67	Q305C	Numeric	8	0	Q305C: Bichil u...	{1, Tiim}...	None	8	Right	Nominal	Input
68	Q305D	Numeric	8	0	Q305D: Oron n...	{1, Tiim}...	None	8	Right	Nominal	Input
69	Q305E	Numeric	8	0	Q305E: Uul uur...	{1, Tiim}...	None	8	Right	Nominal	Input
70	Q305F	Numeric	8	0	Q305F: Bichil u...	{1, Tiim}...	None	8	Right	Nominal	Input
71	Q305G	Numeric	8	0	Q305G: Ashigt ...	{1, Tiim}...	None	8	Right	Nominal	Input
72	Q306Arecod	Numeric	8	0	Q306A: Recodin...	{1, Aumgin l...	None	8	Right	Nominal	Input
73	Q306Brecod	Numeric	8	0	Q306B: Recodi...	{1, nuhun s...	None	8	Right	Nominal	Input
74	Q306Crecod	Numeric	8	0	Q306C: recodin...	{1, huuchin ...	None	8	Right	Nominal	Input
75	Q306Drecod	Numeric	8	0	Q306D: Recodi...	{1, Belcheer...	None	8	Right	Nominal	Input
76	Q306Erecod	Numeric	8	0	Q306E: Recodi...	{1, litsenztel...	None	8	Right	Nominal	Input
77	Q306Frecod	Numeric	8	0	Q306F: Recodi...	{1, nuhuruluu...	None	8	Right	Nominal	Input
78	Q306Grecod	Numeric	8	2	Q306G: Recodi...	{1,00, бага ...	None	8	Right	Nominal	Input
79	Q307	Numeric	8	0	Q307: Ta uunin...	{1, Chaddag...	None	8	Right	Nominal	Input
80	Q308A	Numeric	8	0	Q308A: Garts ...	{1, Tiim}...	None	8	Right	Nominal	Input
81	Q308B	Numeric	8	0	Q308B: Udiridla...	{1, Tiim}...	None	8	Right	Nominal	Input
82	Q308C	Numeric	8	0	Q308C: Olborlo...	{1, Tiim}...	None	8	Right	Nominal	Input
83	Q308Drecod	Numeric	8	0	Q308D: Recong...	{1, Tiim}...	None	8	Right	Nominal	Input
84	Q309	Numeric	8	0	Q309: Ta TBB-i...	{1, adli tege...	None	8	Right	Nominal	Input
85	Q310A	Numeric	8	0	Q310A: Udiridla...	{1, Tiim}...	None	8	Right	Nominal	Input
86	Q310B	Numeric	8	0	Q310B: Medeel...	{1, Tiim}...	None	8	Right	Nominal	Input
87	Q310C	Numeric	8	0	Q310C: Ar gerii...	{1, Tiim}...	None	8	Right	Nominal	Input
88	Q310Drecod	Numeric	8	0	Q310D: recodin...	{1, Apgui b...	None	8	Right	Nominal	Input
89	Q311A	Numeric	8	0	Q311A: Oron n...	{1, Tiim}...	None	8	Right	Nominal	Input
90	Q311B	Numeric	8	0	Q311B: TBB-in...	{1, Tiim}...	None	8	Right	Nominal	Input
91	Q311C	Numeric	8	0	Q311C: Bichil u...	{1, Tiim}...	None	8	Right	Nominal	Input
92	Q311D	Numeric	8	0	Q311D: Salbari...	{1, Tiim}...	None	8	Right	Nominal	Input
93	Q311E	Numeric	8	0	Q311E: AMGazar	{1, Tiim}...	None	8	Right	Nominal	Input
94	Q311F	Numeric	8	0	Q311F: Uul uur...	{1, Tiim}...	None	8	Right	Nominal	Input
95	Q312A	Numeric	8	0	Q312A: Oron n...	None	None	8	Right	Nominal	Input
96	Q312Arecod	Numeric	8	0	Q312A: Recodi...	{1, Olborloiti...	None	8	Right	Nominal	Input
97	Q312AA	Numeric	8	0	Q312A: Aman hu...	{4, Gazniin a...	None	8	Right	Scale	Input
98	Q312B	Numeric	8	0	Q312B: TBB-in...	None	None	8	Right	Nominal	Input
99	Q312Brecod	Numeric	8	0	Q312B: recodin...	{1, Ajiltai bo...	None	8	Right	Nominal	Input
100	Q312BAA	Numeric	8	0	Q312B: Aman h...	{4, aman hu...	None	8	Right	Scale	Input
101	Q312C	Numeric	8	0	Q312C: Bichil u...	None	None	8	Right	Nominal	Input
102	Q312Crecod	Numeric	8	0	Q312C: recodin...	{2, Oron nut...	None	8	Right	Nominal	Input

1.5.2 Мэдээлэл шивэлт болон боловсруулалт

Мэдээлэл шивэлтийг эхлэхийн өмнө буюу мэдээлэл шивэлтийн 2 операторт зориулсан сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтын хүрээнд мэдээлэл шивэлтийн програмыг хэрхэн ажиллуулах, алдаатай мэдээлэл шивэгдсэн тохиолдолд хэрхэн засах, шивэлтийг хэрхэн зохион байгуулах зэрэг сэдвүүд хамрагдсан. Судалгааны

эхний үе дууссаны дараа туршилтын шивэлтийг хийсэн ба туршилтын явцад гарсан алдаа, анхаарах зүйл дээр үндэслэн мэдээлэл шивэлтийн програмыг засаж, сайжруулсан.

Бүх мэдээлэл компьютерт орж дууссаны дараа мэдээлэл датабааз менежер шивэгдсэн мэдээллийн бүтэц, логик уялдаа холбоо, бүрэн бүтэн байдал зэргийг дахин

шалгаж, шаардлагатай зарим засваруудыг хийснээр мэдээлэл эцсийн байдлаар бэлэн болсон. Бэлэн болсон мэдээлэлд цаашдын дүн шинжилгээнд шаардлагатай кодоолтуудыг хийсэн. Тухайлбал, судалгаанд оролцогсдын насыг бүлэглэх, Бусад гэсэн код бүхий

хариултуудыг дахин нягталж, кодлох зэрэг болно. Судалгааны мэдээллийн онцлог байдлаас шалтгаалан мэдээллийг нэгтгэн дахин кодлох явцад хувьсагч нэмэгдэж нийт 174 хувьсагч бүхий баазийг үүсгэж ашигласан. Загварыг доороос харна уу.

	Dugaar	Aimag	Soum	NGO	ID	entry	Huis	Nasaar	Boloversol	Oturul	Q201	Q202A	Q202B	Q202C	Q202D
1	516	13	4	12	26	1	2	4	5	1	2	-	-	-	-
2	473	14	13	17	26	1	1	2	4	2	2	-	-	-	-
3	459	15	13	28	12	1	1	4	3	2	2	-	-	-	-
4	334	14	13	21	21	2	1	2	3	2	2	-	-	-	-
5	364	15	13	26	21	2	1	2	3	2	2	-	-	-	-
6	291	6	10	24	3	5	2	4	4	2	3	2	2	1	1
7	259	6	1	8	3	5	1	4	5	3	3	2	2	2	1
8	415	14	13	20	3	5	2	3	3	2	3	2	2	2	2
9	412	14	13	20	11	5	1	3	4	2	2	-	-	-	-
10	422	14	13	20	10	5	2	3	3	2	1	-	-	-	-
11	426	14	13	20	16	5	2	4	3	2	2	-	-	-	-
12	430	14	13	20	18	5	3	3	3	2	3	2	1	2	2
13	433	15	13	27	1	1	1	3	3	2	3	1	2	1	1
14	553	6	1	8	6	1	1	3	3	3	3	1	2	1	1
15	335	15	10	25	22	2	1	2	5	2	1	-	-	-	-
16	337	15	10	25	25	2	1	3	4	2	2	-	-	-	-
17	365	15	13	26	22	2	1	2	5	2	2	-	-	-	-
18	437	15	13	27	5	1	1	3	3	2	1	-	-	-	-
19	436	15	13	27	6	1	1	3	4	2	1	-	-	-	-
20	464	15	13	28	17	1	1	4	3	1	2	-	-	-	-
21	480	15	13	28	33	1	1	2	1	2	2	-	-	-	-
22	489	14	13	17	42	1	1	3	3	2	2	-	-	-	-
23	164	3	19	6	30	5	2	2	4	2	1	-	-	-	-
24	161	3	19	6	26	5	2	4	3	2	1	-	-	-	-
25	48	3	2	2	29	5	1	4	3	2	2	-	-	-	-
26	369	15	13	26	26	2	1	2	4	2	1	-	-	-	-
27	478	14	13	17	31	1	2	4	3	2	1	-	-	-	-
28	35	3	2	2	27	5	1	2	4	2	1	-	-	-	-
29	45	3	2	2	15	5	1	5	4	2	3	1	1	2	2
30	272	14	9	14	17	5	1	4	4	1	3	2	1	1	2
31	503	13	4	12	13	1	1	1	1	1	2	-	-	-	-
32	522	13	4	12	32	1	1	4	4	1	3	2	1	2	2
33	545	6	1	8	64	1	1	4	1	3	2	-	-	-	-
34	43	3	2	2	4	5	2	2	4	2	2	-	-	-	-
35	528	13	10	13	42	1	2	4	1	1	1	-	-	-	-

1.5.3 Үр дүнгийн шинжилгээ


Эцсийн байдлаар дахин кодлогдож бэлэн болсон мэдээллийг агуулсан PASW Statistics 18.0 (SPSS)

програмын дата файлыг эцэслэсэн. Ингэснээр дараах мэдээллийн файл үүссэн болно. Үүнд:

- PI.sav:** Асуулгад хамрагдсан гишүүдийн мэдээллийн файл
- PA.sav:** ТББ-ын үйл ажиллагаанд гишүүдийн оролцоо
- A and EQ.sav:** ТББ-ын нөлөөллийн ажил, гишүүдийн эрх ба тэгш бус байдал
- FI.sav:** ТББ-ын санхүүжилт ба гишүүдийн оролцоо

Харьцуулсан судалгааны үр дүнгийн хүснэгтүүдийг SPSS програмын синтакс буюу томъёолол боловсруулсны үндсэн дээр суурь судалгааны үзүүлэлтүүдтэй харьцуулах боломжтой байхаар тооцоолж гаргасан. Үр дүнг дундаж, хувийн жин, хамаарлын хүснэгт,

график дүрслэл, тойм статистикийн аргачлалыг ашиглан боловсруулсан. Түүнчлэн судалгааны үндсэн үзүүлэлтүүдийг судалгаанд хамрагдагсдын шинж байдал (нас, хүйс, боловсрол, ашигт малтмалын ордын төрөл зэрэг)-аар тус тус гаргасан.



ХОЁРДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ ХАМРАГДАЛТ БА ХАМРАГДСАН ГИШҮҮДИЙН ШИНЖ БАЙДАЛ

БҮЛГИЙН ТОЙМ

Энэ бүлэгт судалгааны хамрагдалт, судалгаанд хамрагдагсдын шинж байдлыг нас, хүйс, боловсролын түвшин, ашигт малтмалын ордын төрлөөр, судалгааны төлөөлөх

чадварыг нийт болон сонгогдсон БУБ-ын нийт гишүүдийн тоо болон хүйсийн харьцааг график дүрслэл, тойм статистикаар илэрхийлж гаргасан.


2.1. СУДАЛГААНЫ ХАМРАГДАЛТ

Энэ удаагийн судалгаанд 6 аймгийн нийт 26 БУБ-ын 560 гишүүд хамрагдсан байна. Судалгаанд хамрагдах гишүүдийн тоог тодорхойлохдоо тухайн БУБ-ын гишүүдийн тооноос хамаарч ажлын даалгаварт өгөгдсөн тоог харгалзан ялгаатай сонгосон ба эдгээрийн 30.4 хувийг Баянхонгор аймгийн оролцогчид эзэлж байна.

Суурь судалгаанд Баянхонгор аймгаас бичил уурхайн 5 байгууллага сонгогдсон ба энэ удаагийн судалгаанд Бичил уурхайчин баялагийн эзэд БУБ нэмэгдсэнтэй холбоотойгоор бусад аймгуудаас арай олон гишүүн хамрагдсан. Дэлгэрэнгүйг доорх зургаас харна уу.

Зураг 2.1.

Судалгаанд хамрагдсан гишүүдийн тоо, хувь, аймгаар, 2016 он




Судалгааны үр дүнг хүн ам зүйн шинж байдал болох нас, хүйс, нийгмийн шинж байдал болох боловсролын түвшингээр задлан шинжилж үр дүнг

нэгтгэн харуулсан болно. Гишүүдийн хүйсээр хамрагдалтын үзвэл, 38.0 хувийг эмэгтэйчүүд, 62.0 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.

Зураг 2.2.

Судалгаанд хамрагдсан гишүүдийн хувь, хүйсээр, 2015, 2016 он




Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцааг бүртгэлтэй бичил уурхайн байгууллагуудын гишүүдийн хүйсийн

бүтэцтэй харьцуулж доорх зурагт харуулав.

Зураг 2.3.

БУБ-ын нийт, сонгогдсон болон судалгаанд хамрагдсан гишүүдийн хувь, хүйсээр, 2016 он




БУБ-ын гишүүд дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь харьцангуй бага байдаг нь түүвэрт эмэгтэйчүүд бага сонгогдох эрсдлийг нэмэгдүүлдэг талтай. Зураг 2.2-оос харахад судалгаанд хамрагдагсдын хүйсийн бүтэц нь хүйсээр ялгаатай дүн шинжилгээ хийх боломжийг хангахуйц байна. Учир нь судалгаанд сонгогдсон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хамрагдалтыг БУ-н байгууллагуудын хүйсийн бүтэцтэй нилээд ойролцоо, хүйсийн төлөөлөл хангагдахуйц болж чадсан гэж үзэж болох байна.

Судалгаанд хамрагдагсадыг насны бүлгээр авч үзвэл дийлэнх буюу нь 35.0 хувийг 35-44 насныхан, 28.9 хувийг 25-34 насныхан, 27.7 хувийг 45-54 насныхан 5.2 хувийг 55-аас дээш насныхан, 3.2 хувийг 25 хүртэлх насныхан тус тус эзэлж байна. Түүнчлэн, судалгаанд хамрагдсан гишүүдийн дундаж нас 39.6, хамгийн залуу нь 18 настай хамгийн ахмад нь 66 настай 94.5 хувь нь хөдөлмөрийн насны хүмүүс байв. Дэлгэрэнгүйг Зураг 2.4-өөс харна уу.

Зураг 2.4.

Судалгаанд хамрагдсан гишүүдийн хувь насны бүлгээр, 2016 он




Судалгаанд хамрагдсан БУБ-ын гишүүдийг боловсролын түвшинээр үзвэл дийлэнх буюу 47.7 хувь нь бүрэн дунд боловсролтой, 28.4 хувь нь суурь боловсролтой, мэргэжлийн

анхан шатны боловсролтой иргэд 8.9 хувийг, 8.2 хувь нь бага боловсролтой 6.8 хувь нь боловсролгүй гэж хариулсан байна.

Зураг 2.5.

Судалгаанд хамрагдсан гишүүдийн хувь, боловсролоор




Судалгаанд хамрагдсан гишүүдийн ажиллаж буй ашиг малтмалын ордын төрлөөр авч үзвэл дийлэнх нь буюу 53.2 хувь нь шороон ордод 27.9 хувь

нь үндсэн ордод ажиллаж, 18.9 хувь нь жонш олборлодог гишүүд байна. Дэлгэрэнгүйг Зураг 2.6-аас харна уу.

Зураг 2.6.

Судалгаанд хамрагдсан гишүүдийн тоо, хувь, ордын төрлөөр, 2016 он





ГУРАВДУГААР БҮЛЭГ: БИЧИЛ УУРХАЙН БАЙГУУЛЛАГУУДЫН НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ, ГИШҮҮДИЙН ОРОЛЦОО

БҮЛГИЙН ТОЙМ

Энэ бүлэгт БУБ-ын удирдлага болон гишүүдээс эрхээ хамгаалах, шаардах зорилгоор хэрэгжүүлж буй нөлөөллийн ажлууд тэдгээрийн үр дүнг 2015 онд хийгдсэн суурь судалгааны үр дүнтэй харьцуулан

хариулагчдын нас, хүйс болон боловсролын түвшинөөр хийсэн шинжилгээг дундаж, хувийн жин тооцох, график дүрслэл, тойм статистик болон хамаарлын хүснэгтээр харууллаа.

Эрхээ хамгаалах, шаардах зорилгоор БУБ-ын удирдлага болон гишүүдийн зүгээс хийж буй нөлөөллийн ажлыг дараах хэлбэрүүдэд хувааж болох байна.

- БУБ-ын гишүүдээ төлөөлөн удирдлагын зүгээс хэрэгжүүлж буй нөлөөллийн ажил
- БУБ-ын гишүүдийн эрхээ хамгаалах зорилгоор хийж буй нөлөөллийн ажил
- Бичил уурхайн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх нөлөөллийн ажил

Судалгааны дүнгээс харвал БУБ болон бичил уурхайчдаас эрхээ хамгаалах, шаардах зорилгоор хэрэгжүүлж буй нөлөөллийн ажилд зарим ахиц гарч байна. Үүнд дараах хүчин зүйлүүд нөлөөлсөн байна. Үүнд:

- БУБ-уудын удирдлага, гишүүдийн нөлөөллийн ажлын ойлголт, чадвар, оролцоо дээшилсэн
- БУБ болон гишүүдийн эрхээ мэдэх, шаардах мэдлэг сайжирч байгаа
- БУБ-уудаас орон нутагт хийж буй нөлөөллийн ажлын давтамж, хэлбэр нэмэгдэж байгаа
- Зарим БУБ-ууд удирдлага, зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн зэрэг болно.

Түүнчлэн гишүүдийн албан болон албан бусаар хүсэлтээ илэрхийлэхэд дараах шалтгаанууд нөлөөлжээ.

- Орон нутгийн захиргааны зүгээс олборлолтын газрыг хаасан /Дундговь Хулд, Төв Заамар/
- Олон бичил уурхайчид албан ёсоор ажиллах олборлолтын талбай байхгүй, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй УУК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж чадаагүй

3.1. БУ-Н БАЙГУУЛЛАГААС ГИШҮҮДЭЭ ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ, ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ

Бичил уурхайн байгууллагуудаас гишүүдийнхээ эрхээ хамгаалах, дэмжлэг туслалцаа авах зорилгоор холбогдох байгууллага, албан тушаалтанд 107 хүсэлтийг албан ёсоор бичгээр гаргажээ.

Хүснэгт 3.1-ээс БУБ-аас гишүүдийнхээ эрхийг хамгаалах зорилгоор гаргаж байсан албан

хүсэлтүүдийг харж болно. БУБ-ын удирдлагууд гишүүдийнхээ эрхийг хамгаалах зорилгоор аймаг/сумын удирдлага болон тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа УУК-дад хамтран ажиллах албан хүсэлтээ гаргах нь нилээд түгээмэл байдаг байна.

Хүснэгт 3.1

Гишүүдээ төлөөлж БУБ-ын удирдлагаас албан хүсэлт гаргаж буй байдал, 2016 он

	Орон нутгийн захиргаанд газар олгох хүсэлт	УУКомпанид хамтран ажиллах гэрээ байгуулах хүсэлт	Бусад	Бүгд тоо
Батсайхан сэтгэл	Тийм	Тийм	Нөхөн сэргэлтэнд оролцох	13
Алтан усны хөгжил	Тийм	Тийм	Нөхөн сэргэлтэнд оролцох	11

ХАМО ДХ	Тийм	Тийм	Шаламны орлого хуваах	6
Баян бөмбөгөр	Тийм	Тийм	Нөхөн сэргэлтэнд оролцох	11
Байдрагийн хөгжил	Тийм	Тийм	Нөхөн сэргэлтэнд оролцох	8
Эх орон хамтын хүч	Тийм	Тийм		3
Хутагтын үр сад	Тийм	Тийм	Тийм	5
Өлзийт хишиг буян	Тийм	Тийм	Олборлосон жоншны агууламж тогтоолгох	6
Тахилгат лусын булаг	Тийм		ОН удирдлагад нөлөөлөл (МБУНДХ)	5
Хулд хөгжлийн төлөө хамтдаа	Тийм	Тийм	Тийм	2
Баатар вангийн хишиг	Тийм	Тийм	ОН өмчит тээрмийг БУ-чдад ашиглуулах	3
Дууш Мандал	Тийм	Тийм	Шаламны орлого хуваах	5
Бичил уурхайчдын холбоо	Тийм	Тийм	Нөхөн сэргэлтэнд оролцох	3
Заамар-1	Тийм	Тийм	Тийм	8
Заамар-2	Тийм	Тийм	Тийм	6
Бид намырын эзэд	Тийм	Тийм	Тийм	2
Баян нутгийн хишиг	Тийм	Тийм	Тийм	2
Цахир хүзүүвч	Тийм	Тийм	Нөхөн сэргэлтэнд оролцох	5
Алтан тэвшийн цэцэг	Тийм	Тийм	Нөхөн сэргэлтэнд оролцох	3
Баялгийн эзэн БУ	Тийм	Тийм		1
Чандмана Уул андууд	Тийм	Тийм	Нөхөн сэргэлтэнд оролцох	1
Нийт				109

Товч дүгнэж үзвэл БУБ-ын удирдлагууд гишүүдийн эрхийг хамгаалах зорилгоор гаргаж буй хүсэлтээ албан ёсоор бичгээр илэрхийлэх, баримтжуулах нь суурь

судалгааны үетэй харьцуулахад нэмэгдсэн байна. Ихэнх БУБ гаргасан албан хүсэлтийн хуулбар холбогдох бусад бичиг баримт, гэрэл зургийг архивлан хадгалсан байна.



Шигтгээ:

Баянхонгор аймгийн ЗДТГазраас зохион байгуулсан уул уурхайн зөвлөгөөнд БУБ-ын төлөөлөл оролцож бичил уурхайн талаар санал бодлоо солилцож аймгийн ИТХ, Засаг дарга, УУК-ниудад 8 байгууллага 11 хүсэлтийг өгсөн байна.

Жишээ болгон Алтан усны хөгжил БУБ-ын хүсэлтийн фото хуулбарыг харуулав.

Манай дарга нар сумын захиргаа, энд ажиллаж байгаа компаниудад хамтран ажиллах хүсэлтээ гаргадаг. Сумын удирдлага ажиллаж байсан газрыг хууль бусаар хаасан тул аймгийн ЗД-д өргөдөл гаргасан.


Төв аймаг Заамар сумын Бичил Уурхайчин эмэгтэй

БУБ-ууд ихэвчлэн гишүүдээ олборлолтын газартай болгох, нөхөн сэргээлтийн төсөлд хамруулах, УУК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулах чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтанд

хүсэлтээ гаргадаг байна. Судалгаанд хамрагдсан гишүүдийн 38.8. хувь нь орон нутгийн захиргаанд, 31.6 хувь нь орон нутагт ажиллаж байгаа УУК-нд гэрээ хийх албан хүсэлтээ гаргасан гэжээ.

Зураг 3.1.

Гишүүдээ төлөөлж гэрээ хэлцэл хийсэн байдал хувиар, 2015, 2016 он



Суурь судалгааны үетэй харьцуулж үзвэл орон нутгийн захиргаатай гэрээ хэлцэл хийдэг гэж үздэг гишүүдийн хувь 8.1 пунктээр, УУК-тай гэрээ хэлцэл хийдэг гэсэн гишүүдийн хувь 2.5 пунктээр тус тус өсчээ. Орон нутгийн удирдлагууд бичил уурхайчдыг ойлгож дэмжих

хүсэлтэй боловч ихэнх талбай нь лицензтэй, өөр эзэмшигчтэй тул бие даан шийдвэрлэж чаддаггүй учраас шахаж шаардаад ч нэмэргүй гэж тодруулсан байна. /Баянхонгор Баян-Овоо, Галуут, Дорноговь Айраг, Төв Борнуур/



Шигтгээ:

Баянхонгор аймгийн Галуут сумын Батсайхан сэтгэл БУБ-аас өнгөрсөн 2015-2016 онд аймаг/сумын ЗДаргад газар олгож өгөх, гурвалсан гэрээ байгуулах, аймгийн ХХҮГазарт нөхөн сэргээлтэнд оролцох, Жамп ХХК хамтран ажиллах гэрээ байгуулах зэрэг нийт 13 хүсэлтийг илгээжээ.

Жишээ болгон Жамп ХХК-д гаргасан гэрээ байгуулах хүсэлтийн фото хуулбарыг харуулав.

БУБ-ын удирдлагаас гишүүдээ төлөөлөн хийж буй нөлөөллийн ажлыг хэрхэн үнэлж байгааг хүйсийн ялгаатай байдлаар авч үзвэл эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн хувьд адилхан нэмэгдсэн байна.


Гэхдээ орон нутгийн захиргаатай

гэрээ хэлцэл хийдэг гэж үздэг эмэгтэйчүүд арай өндөр буюу 3.9 пунктээр нэмэгджээ.

Харин УУК-тай гэрээ хэлцэл хийдэг гэж үздэг эрэгтэй гишүүдийн хувь 11.3 пунктээр өссөн байна.

Зураг 3.2.

Гишүүдээ төлөөлж гэрээ хэлцэл хийсэн байдал, хүйсээр, хувиар, 2015, 2016 он



3.2. БИЧИЛ УУРХАЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ, МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ

БУБ-уудаас орон нутагт явуулж буй нөлөөллийн ажлын нэг хэлбэр нь олон нийтийн хандлагыг өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагаа байна. Тухайлбал бичил уурхайн талаарх орон нутгийн иргэд, малчдын сөрөг хандлагыг бууруулах, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилго бүхий, өдөрлөг зохион байгуулах,

үйл ажиллагаагаа сурталчлах ажлыг хийдэг байна. Түүнчлэн орон нутагт зохион байгуулж байгаа хурал уулзалтанд оролцож БУБ-аа танилцуулж, санал хүсэлтээ илэрхийлж байгаа нь гишүүдээ төлөөлж нөлөөллийн ажил хийж буй нэг хэлбэр гэж үздэг байна.

Багийн Засаг даргатай хамтран БИНХуралд танилцуулга хийх, хөдөөгийн айл өрхүүдэд мэдээлэл өгч, БУБ-ын танилцуулгыг хар болон өнгөтөөр хэвлэж УУК, сум, багийн иргэдэд тараасан.

Баянхонгор аймаг, Бөмбөгөр сум, Баян бөмбөгөр БУБ, Төв аймаг, Заамар сум, Намсрай Заамар БУБ

Үйл ажиллагаа явуулж байгаа Багийн Засаг, дарга, малчидтай гурвалсан гэрээ хийж хашаа хороо барьж өгөх, засаж сэлбэх ажил хийж өгдөг


Баянхонгор аймаг, Алтан усны хөгжил БУБ, Батсайхан сэтгэл БУБ

Олон нийтийн ойлголт, хандлагыг өөрчлөх талаар хийж байгаа ажил тодорхой үр дүнд хүрч байгаа гэж гишүүд үздэг байна. Тодруулбал эрэгтэй гишүүдийн 53.7 хувь нь, эмэгтэй гишүүдийн 52.5 хувь нь олон нийтийн дэмжлэгийг авах,

хамтран ажиллах зорилгоор хийсэн нөлөөллийн ажлуудын үр дүнд иргэд, малчдын хандлага сайжирч байгаа гэж хариулжээ. Энэ нь суурь судалгаанаас 4.5 болон 6.6 пунктээр өссөн үзүүлэлт болж байна. Зураг 3.3-аас харна уу.

Зураг 3.3.

Олон нийтийн хандлага сайжирсан гэж хариулсан гишүүдийн хувь, хүйсээр, 2015, 2016 он




Олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлын үр дүнг орон нутгийн иргэд, малчдын ойлголт хандлага сайжирч тэдний зүгээс үзүүлж буй шахалт, дарамт буурч байгаагаас

харж болохоор байна. Тухайлбал судалгаанд хамрагдсан гишүүдийн 7.5 хувь нь орон нутгийн иргэд, малчдаас үзүүлж буй шахалт, дарамт буурсан гэж хариулжээ.

БУБ-ын гишүүд малчдын өвөлжөө, хаваржаа барьж өгөх зэргээр хамтын ажиллагаагаа сайжруулж өөрсдийн ажлаа сурталчлан ойлгуулж байгаатай холбоотой гэж тайлбарласан байна. Тодруулбал Алтан Усны хөгжил, Батсайхан сэтгэл, Дууш Мандал зэрэг 10 гаруй БУБ үйл ажиллагаагаа иргэдэд сурталчлах өдөрлөг зохион байгуулжээ. ХАМОДХ, Өлзийт хишиг буян зэрэг 9 байгууллага орон нутгийн зам, гүүр засах, худаг гаргах, цэвэрлэх, бүх нийтийн цэвэрлэгээ, тохижилтын ажилд оролцох, орон нутагт хандив өгөх зэргээр олон нийтийн нөлөөллийн ажил хийсэн гэжээ.

Зураг 3.4.

Орон нутгийн иргэд, малчдаас шахалт, дарамт үзүүлж байгаа гэж хариулсан гишүүдийн хувь, хүйсээр, 2015, 2016 он



Хүйсийн ялгаатай байдлаар харвал орон нутгийн иргэд, малчдаас үзүүлдэг дарамт, шахалт эрэгтэйчүүд

хувьд 6.3 пунктээр, эмэгтэйчүүд хувьд 9.6 пунктээр тус тус буурсан гэж үзсэн байна.


3.3. ЭРХЭЭ ШААРДАХ, ЭРХЭЭ ХАМГААЛАХ САНААЧЛАГА, ГИШҮҮДИЙН ОРОЛЦОО, ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ

Дээр дурьдсанчлан гишүүдийн хувьд ч нөлөөллийн ажилд оролцох идэвх санаачлага, эрхээ шаардах санал,

хүсэлт гаргахад оролцох оролцоо нэмэгдсэн байна.

Зураг 3.5.

Албан хүсэлтийн хувь, гаргасан байгууллагаар, 2015, 2016 он



Судалгаанд хамрагдсан гишүүдийн 21.4 хувь орон нутгийн захиргаандаа, 16.8 хувь нь БУБ -ынхаа удирдлагад, 15.7 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулж буй УУК-д, 3.2 хувь нь МБУНДХолбоонд, 0.7 хувь нь АМГТГазарт өөрийн хүсэлтээ албан ёсоор гаргахад оролцож байсан гэжээ. (Судалгааны явцад оролцогчид төрөл бүрийн хүсэлтээ гаргаж байсан гэж мэдээлж байсан боловч албан бичгээр баталгаажаагүй зөвхөн аман хэлбэрээр гаргаж байсан тул судалгааны үр дүнд оруулж тооцоогүй болно.)

2015 оны суурь судалгааны үр дүнтэй харьцуулж үзвэл орон нутгийн захиргаандаа хүсэлт гаргахад оролцсон гишүүдийн хувь 13.8 пунктээр, БУБ-ынхаа удирдлагад гаргаж байсан хүсэлт 11.2 пунктээр, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй УУК-д хүсэлт гаргахад оролцсон

гишүүдийн хувь 14.6 пунктээр тус тус өссөн байна.


Бичил уурхайчид өөрийн санал, хүсэлтээ хамгийн ойрхон байрлах орон нутгийн захиргаа хандаж гаргах нь нийтлэг байна. (Аймаг, сумын ИТХурал болон Засаг даргад хандаж гаргасан хүсэлтүүдийг нэгтгэн авсан.) Байгууллага, албан тушаалтанд хандан хүсэлтээ илэрхийлж буй байдлыг хүйсээр ангилан суурь судалгаатай харьцуулбал эрэгтэйчүүд хувь 15.2 пунктээр, эмэгтэйчүүд хувь 11.7 пунктээр тус тус нэмэгджээ.

БУБ-даа гаргасан хүсэлтийн тоог суурь онтой харьцуулж үзвэл эмэгтэйчүүд эрчүүдээс 13.6 хувиар өндөр байна.

Суурь судалгаанаас хойшх хугацаанд УУК-д хандан хамтран ажиллах хүсэлт гаргадаг эрэгтэйчүүд 15.2 хувиар, эмэгтэйчүүд 13.7 хувиар тус тус нэмэгджээ.

Зураг 3.6.

Албан хүсэлтийн хувь, гаргасан байгууллагаар, хүйсээр, 2015, 2016 он



Хүсэлтээ илэрхийлж байгааг байдлыг нас, боловсролын түвшинээр нь гарган суурь судалгааны үр дүнтэй харьцуулсан дүнг хүснэгт 3.2-оос харна уу.

Бүх насны бүлгийн хувьд МБУНДХ болон АМГТГ-аас бусад байгууллага албан тушаалтанд хандаж хүсэлтээ гаргасан гишүүдийн хувь, төрлөөр нэмэгдсэн байна.

Бүх насны бүлгийн хувьд Орон нутгийн захиргаанд гаргасан хүсэлт нэмэгдсэн ба 25-34 насны гишүүдийн хувьд 17.5 пунктээр нэмэгдсэн нь бусад насны бүлгүүдээс харьцангуй өндөр байна.

БУБ-даа хүсэлт гаргаж байсан 45-54 насны гишүүд суурь судалгааны үеэс 23.9 болж нэмэгдсэн бол 55+ насны гишүүдийн тоо буурсан байна.

Хүснэгт 3.2

Албан хүсэлтийн хувь, гаргасан байгууллагаар, насны бүлгээр, боловсролоор, 2015, 2016 он

	Орон нутгийн захиргаан даа		ТББ-ын удирдлага даа		Уул уурхайн компанид		МБУНДХ		АМГТ Газарт	
	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
Эрэгтэй	6.1	21.2	4.3	14.0	0.6	15.8	0.3	2.3	0.3	0.9
Эмэгтэй	10.1	21.8	7.7	21.3	1.9	15.6	1.9	4.7	1.4	0.5
<25	5.1	22.2	5.1	11.1	0	16.7	1.7	5.6	1.7	-
25-34	5.3	22.8	3.3	12.3	0.7	9.3	0	1.9	0	1.2
35-44	10.5	19.4	8.7	17.3	1.2	19.9	0	4.1	0.6	0.5
45-54	7.6	22.6	2.5	23.9	1.7	16.8	3.4	3.9	1.7	0.6
55+	8.6	20.7	11.4	3.4	2.9	17.2	0	0	0	-
Боловсролгүй	0	34.2	9.1	18.4	0	18.4	0	2.6	0	-
Бага	6.1	10.9	6.1	13.0	1.5	4.3	0	6.5	0	-
Суурь	5.9	24.5	3.4	18.9	0.8	16.4	0.8	2.5	0	1.3
Бүрэн дунд	9.1	19.9	5.5	16.1	0.7	14.6	1.1	3.4	1.5	0.7
Мэргэжлийн анхан шатны	3.6	20.0	7.1	16.0	7.1	28.0	0	2	0	-
Үндсэн орд	2	20.3	5.1	10.5	0	10.5	0	0.7	0	-
Шороон орд	6.6	21.8	5.6	22.8	1.7	20.4	1.4	3.1	0.7	1.4
Жонш	12.6	21.9	5.2	10.2	0	10.9	0.7	6.3	0.7	-
Судалгааны дундаж	7.6	21.4	5.6	16.8	1.1	15.7	0.9	3.2	0.7	0.7

Боловсролын түвшинөөр авч үзвэл Орон нутгийн захиргаанд хүсэлтээ гаргаж буй тохиолдол бүх түвшиний хувьд нэмэгдсэн ба өмнө нь хүсэлт

гаргаж байгаагүй боловсролгүй хүмүүс хамгийн их буюу 34.2 хувиар нэмэгджээ.

Түүнчлэн 24.5 хувь нь орон нутгийн захиргаандаа хандаж хүсэлтээ гаргасан суурь боловсролтой

гишүүдийн хувь суурь судалгааны үеэс 18.6 пунктээр нэмэгджээ.

3.3.1 Орон нутгийн захиргаанд илгээсэн хүсэлтийн тоо, төрөл


Судалгааны явцад олон төрлийн байгууллагад янз бүрийн хүсэлтүүдээ илгээж байсан талаар мэдээлэл өгч байсан ба голлох байгууллагад албан тушаалтанд олон тооны давтамжтайгаар гаргасан хүсэлтүүдийн талаар дэлгэрүүлж тайлбарласан ба цөөн давтамжтай бусад хүсэлтүүдийг нэгтгэн хүснэгтэн мэдээлэл болгон харуулсан болно.

Судалгааны дүнгээс харахад БУБ-ын гишүүдээс орон нутгийн удирдлагад

хандан 91 хүн 122 хүсэлтийг илгээхэд оролцсон ба энэ нь 2015 оны суурь судалгааны үеэс 67.2 хувиар өссөн байна. Орон нутгийн удирдлагадаа хандан албан ёсоор бичгээр гаргаж байсан хүсэлтүүдийг төрлөөр нь авч үзвэл тогтмол ажлын байр буюу олборлолтын газартай болох хүсэлт (91) давамгайлах хандлага хэвээрээ ба суурь судалгааны үеэс 60.4 хувиар өсчээ.

Зураг 3.7.

Орон нутгийн захиргаанд гаргасан албан хүсэлтийн тоо, төрөл, 2015, 2016 он



Орон нутгийн удирдлагадаа хандан албан ёсоор бичгээр гаргаж байсан хүсэлтийг нас, хүйс, боловсрол, ордын төрлөөр гаргаж хүснэгт 3.3-д харуулав.

Суурь судалгаагаар орон нутагт

хандан зөвхөн газрын хүсэлт гаргаж байсан учраас хүсэлтийн төрөл нэмэгдсэнтэй холбоотойгоор суурь судалгаатай харьцуулан хувиар илэрхийлэх боломжгүй юм.

Хүснэгт 3.3

Орон нутгийн удирдлагад гаргасан албан хүсэлтийн тоо, төрлөөр, нас, хүйс, боловсролоор, 2015, 2016 он


	Тогтмол ажлын байтай буюу газартай болох		Төслийн зээлд хамруулах		ОН-ийн өмчит тээрмийг БУ-дад ашиглуулах	Шаламны орлого хуваах
	2015	2016	2015	2016	2016	2016
Эрэгтэй	18	59	2	9	2	5
Эмэгтэй	18	32	2	11	3	1
<25	3	5	0	0	0	0
25-34	6	25	2	7	1	4
35-44	16	29	1	6	1	2
45-54	9	28	0	6	2	0
55+	2	4	1	1	1	0
Боловсролгүй	0	9	0	2	2	0
Бага	4	4	0	0	0	1
Суурь	7	30	0	9	0	0
Бүрэн дунд	20	39	4	9	2	4
Мэргэжлийн анхан шатны	1	9	0	0	1	1
Үндсэн орд	5	13	0	5	5	6
Шороон орд	23	50	0	14	0	0
Жонш	8	28	4	1	0	0
Хүсэлтийн тоо	36	91	4	20	5	6

3.3.2 БУБ-ын удирдлагад гаргасан хүсэлтийн тоо, төрөл

Судалгааны явцад 78 гишүүн өөрийн албан хүсэлтээ БУБ-ын удирдлагадаа гаргасан ба давхардсан тоогоор нийт 98 хүсэлтийг гаргасан гэжээ. Үүний 78 нь олборлолтын газартай болох үлдсэн 20 нь нөхөн сэргээлтийн төсөлд оролцох хүсэлт байна. Суурь судалгаатай харьцуулж үзвэл олборлолтын газрын хүсэлт 61.5 хувиар өсжээ. Хэдийгээр гишүүд албан өргөдөл, бичгээр хүсэлтээ

илэрхийлдэггүй боловч байгууллага, хамт олны хурлаар шийдвэрлэдэг тул албан хүсэлт гэж үзэж байлаа. Тухайлбал орон нутгийн захиргаа, Азийн сангийн нөхөн сэргээлтийн төслүүд, ТБУТөслөөс хэрэгжүүлж буй жижиг төслүүдэд оролцох хүний тоо хязгаартай байдаг ба БУБ-ын болон нөхөрлөлийн хурлаас хэлэлцэн оролцоог шийддэг тул энэ нь албан хүсэлт болно гэж байлаа.

Зураг 3.8.

БУБ-ын удирдлагад гаргасан албан хүсэлтийн тоо, төрөл, 2015, 2016 он

БУБ-ын удирдлагадаа санал, хүсэлтээ илэрхийлж байсан гишүүдийг нас, хүйс, боловсролын түвшинээр нь шинжилж хүснэгт 3.4-д харуулав.

Хүснэгтээс харахад гаргаж буй хүсэлтийн төрлөөс хамаарч хүйсийн хувьд зарим ялгаа байна. Тодруулбал БУБ-ын удирдлагадаа

“ажлын байртай буюу газартай болох” хүсэлтээ илэрхийлсэн эмэгтэй гишүүдийн хувийн жин эрэгтэй гишүүдийнхээс 23.2 хувиар илүү байна. Ерөнхийдөө эмэгтэй гишүүд өөрийн БУБ-даа хандан хүсэлтээ гаргах нь илүү байдаг байна.

Хүснэгт 3.4

БУБ-ын удирдлагад гаргасан хүсэлтийн тоо, төрлөөр, нас, хүйс, боловсролоор, 2015, 2016 он

	Тогтмол ажлын байртай буюу газартай болох		Нөхөн сэргээлтэнд оролцох		Шламны орлого хуваах		Тоо
	Хүсэлтийн тоо	Эзлэх хувь	Хүсэлтийн тоо	Эзлэх хувь	Хүсэлтийн тоо	Эзлэх хувь	
Эрэгтэй	33	61.1	15	27.8	6	11.1	54
Эмэгтэй	38	84.4	7	15.6	0	-	45
<25	2	100.0	0	-	0	-	2
25-34	14	60.9	5	21.7	4	17.4	23
35-44	25	69.4	9	25.0	2	5.6	36
45-54	29	78.4	8	21.6	0	-	37
55+	1	100.0	0	-	0	-	1
Боловсролгүй	5	71.4	2	28.6	0	-	7

Бага	5	62.5	1	12.5	2	25.0	8
Суурь	22	71.0	6	19.4	3	9.7	31
Бүрэн дунд	33	73.3	11	24.4	1	2.2	45
Мэргэжлийн анхан шатны	6	75.0	2	25.0	0	-	8
Үндсэн орд	12	63.2	1	5.3	6	31.6	19
Шороон орд	46	68.7	21	31.3	0	-	67
Жонш	13	100.0	0	-	0	-	13
Тоо	71	71.7	22	22.2	6	6.1	99

Насаар авч үзвэл 25 хүртэлх болон 55+ насны гишүүд хүсэлтээ гаргах нь бага байдаг байна. Тодруулбал эдгээр хариулагчид зөвхөн газартай болох хүсэлт (3) гаргасан байна. 35-44 болон 45-54 насны хүмүүс л дийлэнх хүсэлтийг гаргасан байна.

Боловсролоор нь авч үзвэл суурь болон бүрэн дунд боловсролтой гишүүд хүсэлтээ гаргах нь илүү

байдаг байна. Нийт хүсэлтийн 32.0 хувийг суурь боловсролтой, 50.0 хувийг нь бүрэн дунд боловсролтой гишүүд гаргажээ.

Ордын төрлөөр авч үзвэл шороон ордод ажилладаг гишүүд дийлэнх буюу 59.0 хувийг нь эзэлж байна. Шороон ордод ажиллаж буй ихэнх БУ-чид тогтсон олборлолтын газаргүйтэй холбоотой.


3.3.3 УУКомпаний удирдлагад гаргасан хүсэлтийн тоо, төрөл

Бичил уурхайчид олборлолтын газартай болохын тулд нөхөрлөл болон БУБ-тай хамтарсан хэлбэрээр орон нутагт үйл ажиллагаа явуулж

байгаа УУК-д хандан хүсэлтээ илэрхийлэх нь нилээд түгээмэл байдаг байна.

Зураг 3.9.

УУК-ний удирдлагад гаргасан албан хүсэлтийн тоо, хүйсээр, 2015, 2016 он



Хүйсээр нь харвал орон нутагт үйл ажиллагаа явуулж буй УУК-д хамтын гэрээ байгуулах хүсэлтээ гаргаж буй эрэгтэй, эмэгтэй гишүүдийн тоо суурь оноос өссөн ба эрэгтэйчүүд нийт хүсэлтийн 65.0 хувийг гаргажээ. Зураг 3.9-өөс харна уу.

Орон нутаг үйл ажиллагаа явуулж буй УУК-д хамтын гэрээ байгуулах

хүсэлтээ гаргахад оролцсон гишүүдийг насны бүлгээр нь авч үзвэл 35-44 насны гишүүдийн оролцоо илүү байна. Тодруулбал 35-44 насны 39 хүн гурвалсан гэрээ байгуулах хүсэлт гаргасан нь бусад бүлгийн гишүүдээс илүү буюу нийт хүсэлтийн 44.3 хувийг энэ насны гишүүд гаргасан байна.

Хүснэгт 3.5

УУКомпанид гаргасан албан хүсэлтийн тоо, нас, хүйс, боловсролоор, 2015, 2016 он

	2015			2016			
	Тоо	Судалгааны дүнд эзлэх хувь	Нийт тоо	Тоо	Судалгааны дүнд эзлэх хувь	Нийт тоо	Өөрчлөлтийн хувь
Эрэгтэй	2	0.6	329	55	15.8	347	15.1
Эмэгтэй	3	1.4	207	33	15.6	213	14.2
<25	0	-	59	3	16.7	18	16.7
25-34	1	0.7	152	15	9.3	162	8.5
35-44	1	0.6	172	39	19.9	196	19.3
45-54	2	1.7	118	26	16.8	155	15.0
55+	1	2.9	35	5	17.2	29	14.3
Боловсролгүй	0	-	11	7	18.4	38	18.4
Бага	0	-	66	2	4.3	46	4.3
Суурь	1	0.8	119	26	16.4	159	15.5
Бүрэн дунд	2	0.7	275	39	14.6	267	13.9
Мэргэжлийн анхан шатны	2	7.1	28	14	28.0	50	20.9
Судалгааны дундаж	5	0.9	536	88	15.7	560	14.8

3.3.4 Бусад хүсэлтүүдийн талаар

Хэдий цөөхөн тооны боловч эрхээ хамгаалах, шаардах ойлголт, мэдлэг сайжирч байгаатай холбоотойгоор “орон нутгийн өмчит тээрмийг БУ-дад ашиглуулах”, “шамны орлого хуваах”, “шлам ашиглах” зэрэг хүсэлтүүдийг гаргаж байсан байна.

Суурь судалгаагаар БУБ-ын гишүүн бичил уурхайгаар ашиглаж болох

эсэх талаар газрын дүгнэлт гаргуулах, солбилцол тогтоолгох 4 хүсэлт илгээхэд оролцсон гэжээ. Гэвч хүсэлт гаргах шат дамжлага олон, ашиглах боломжгүй гарцгүй газарт дүгнэлт гаргадаг, заримдаа огт дүгнэлт гаргаж өгдөггүй зэрэг хүндрэлүүд гардаг гэж тайлбарлаж байсан. Дэлгэрнгүйг хүснэгт 3.6-аас харна уу.

Хүснэгт 3.6

2016 онд шинээр гаргасан хүсэлтийн тоо, төрлөөр, байгууллагаар

Шинээр гаргасан хүсэлт	Хандаж гаргасан байгууллага, албан тушаалтай	Тоо
Орон нутгийн өмчит тээрмийг БУ-дад ашиглуулах	Орон нутгийн захиргаанд	5
Шаламны орлого хуваах	Орон нутгийн захиргаанд	6
Сургалт авах	МБУНДХолбоонд	1
Орон нутгийн удирдлагатай газрын асуудлаар уулзалт хийх	МБУНДХолбоонд	15
Шлам ашиглах хүсэлт, газрын дүгнэлт гаргуулах	Орон нутгийн захиргаа, АМГТГазарт	4
		28

Бид нар дуугүй явсаар байгаад орон нутгийн хөрөнгөөр боссон жижиг тээрмийг хуучин Засаг даргад алдчихсан. Одоо тэр хүн үүнийг ашиглаад сул орлого олоод сайхан амьдарч байна. Гэтэл бичил уурхайчид бид мөнгөө төлж чулуугаа тээрэмдүүлж байна. Тэгэхээр орон нутгийн хөрөнгөөр бий болсон тээрмийг бичил уурхайчдад ашиглуулах талаар орон нутагт албан хүсэлтээ гаргасан

Сэлэнгэ, Мандал сум, Түнхэл баг эрэгтэй Бичил уурхайчин

IV

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: БИЧИЛ УУРХАЙН БАЙГУУЛЛАГУУДЫН УДИРДЛАГА БА ГИШҮҮДИЙН ОРОЛЦОО

БҮЛГИЙН ТОЙМ

Энэ бүлэгт БУБ-ын удирдлага, шийдвэр гаргах процесст гишүүдийн оролцоо, ялгаатай байдал, оролцож чадахгүй байгаа шалтгаан, БУБ-аас гишүүдээ үзүүлж буй дэмжлэг, гишүүн болсны давуу тал тэдгээрт гарч буй өөрчлөлтийг суурь судалгааны

дүнтэй харьцуулан танилцуулав. Хариулагчдын хүйс, нас болон боловсролын түвшинээр хэр ялгаатай байгааг шинжлэн үр дүнг график дүрслэл, тойм статистик болон хамаарлын хүснэгтээр харууллаа.


4.1. БУБ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛЖ БУЙ АЖИЛД ГИШҮҮДИЙН ОРОЛЦОО БА ЯЛГААТАЙ БАЙДАЛ, ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ

Энэ хэсэгт БУБ-аас хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд гишүүдийн оролцооны түвшин, оролцож чаддаггүй шалтгаан, гарч буй өөрчлөлтийг тодруулж тайлбарласан. Судалгааны үр дүнгээс харахад БУБ-

аас хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд гишүүдийн 25.5 хувь нь оролцож чаддаг, 44.5 хувь нь хааяа оролцдог, 30.0 хувь нь оролцож чадахгүй байна гэж хариулжээ. Зураг 4.1-ээс харна уу.

Зураг 4.1.

БУБ- аас зохион байгуулж байгаа ажилд гишүүдийн оролцож буй байдал, хувиар, 2015, 2016 он




Суурь судалгааны үеэс тогтмол оролцож чаддаг гишүүдийн хувь 2.2 пунктээр, хааяа оролцдог гишүүдийн хувь 6.6 пунктээр тус тус нэмэгдсэн нь гишүүдийн оролцоо, сонирхол бага боловч дээшилж байгааг харуулж байна.

Судалгаанд гишүүдийн оролцоог суурь судалгааны дүнтэй харьцуулж үзвэл үйл ажиллагаандаа оролцож чаддаг эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийнхээс 3.0 пунктээр илүү өссөн байна. Дэлгэрэнгүйг зураг 4.2-оос харна уу.

Зураг 4.2.

БУБ-аас зохион байгуулж байгаа ажилд гишүүдийн оролцож буй байдал, хувиар, хүйсээр, 2015, 2016 он



Гишүүдийн оролцооны түвшинд гарсан өөрчлөлтийг нас болон боловсролын түвшиний ялгаатай байдлаар хүснэгт 4.1 –д харуулав.

45-54 болон 55+ насны бүлгийн хувьд оролцож чаддаг гишүүд 5.3 болон

5.8 пунктээр нэмэгдэж оролцож чаддаггүй гишүүд 15.6 болон 24.6 пунктээр тус тус буурч оролцоо нь сайжирсан байна. Бусад насны бүлгийн хувьд төдийлөн ялгаа алга байна.

Хүснэгт 4.1.

БУБ-аас зохион байгуулж байгаа ажилд гишүүдийн оролцож буй байдал, хувиар, насны бүлгээр, боловсролоор, 2015, 2016 он

	2015			2016		
	Чаддаг	Хааяа оролцдог	Оролцож чаддаггүй	Чаддаг	Хааяа оролцдог	Оролцож чаддаггүй
<25	27.1	35.6	37.3	25.5	44.5	30.0
25-34	20.4	46.1	33.6	27.8	44.4	27.8
35-44	26.7	39.0	34.3	24.1	48.8	27.2
45-54	21.2	30.5	48.3	26.5	40.8	32.7
55+	20.0	25.7	54.3	25.8	44.5	29.7
Боловсролгүй	18.2	54.5	27.3	21.1	39.5	39.5
Бага	18.2	50.0	31.8	17.4	50.0	32.6
Суурь	21.0	36.1	42.9	24.5	44.7	30.8
Бүрэн дунд	26.2	34.9	38.9	27.7	44.6	27.7
Мэргэжлийн анхан шатны	14.3	46.4	39.3	28.0	42.0	30.0
Судалгааны дундаж	23.3	37.9	38.8	25.5	44.5	30.0

Боловсролын түвшинээр нь авч үзвэл суурь боловсролтой гишүүдийн хувьд оролцоо сайжирсан байна. Тодруулбал эдгээр гишүүдийн оролцож чаддаг нь 3.5 пунктээр, хааяа оролцож байгаа нь 8.6 пунктээр нэмэгдэж огт оролцож чаддаггүй гишүүдийн хувь 12.1 пунктээр буурч чаджээ.

Харин бага боловсролтой гишүүдийн оролцоо буурсан байна. Хэдийгээр

тогтмол оролцож чаддаг гишүүдийн хувь нь 2.9 пунктээр нэмэгдсэн ч гэлээ хааяа оролцдог гишүүд 15.0 пунктээр буурч огт оролцож чаддаггүй гишүүдийн хувь 12.2 пунктээр өссөн нь судалгааны дунджаас 1.4 дахин өндөр байна. Бусад түвшиний боловсролтой гишүүдийн хувьд оролцооны түвшин ерөнхийдөө дээшилсэн хандлагатай байна.


4.2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ ГИШҮҮДИЙН ОРОЛЦОО БА ЯЛГААТАЙ БАЙДАЛ, ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ

Судалгааны явцад гишүүдийн оролцоог үйл ажиллагааны төрлөөр тодруулж гаргасан. (Зөвхөн зохион байгуулж буй ажилд оролцож чаддаг болон хааяа оролцдог гэж хариулсан гишүүдээс тодруулж асуусан болно.)

Судалгаанд хамрагдсан гишүүдийн 85.0 хувь нь олборлолт хийхэд, 54.0 хувь нь бүх төрлийн сургалтанд оролцдог гэж хариулсан ба суурь судалгааны үеэс өссөн байна. Дэлгэрэнгүйг зураг 4.3-аас харна уу.

Зураг 4.3.

БУБ-аас зохион байгуулж байгаа ажилд гишүүдийн оролцож буй байдал, хувиар, ажлын төрлөөр, 2015, 2016 он



2015 онд хийсэн суурь судалгааны дүнтэй харьцуулж үзвэл сургалтанд оролцсон гишүүд 43.1 пунктээр, олон нийтийн нөлөөллийн ажилд оролцсон гишүүд 10 пунктээр, олборлолт

хийхэд оролцсон гишүүд 4.0 пунктээр тус тус нэмэгдсэн байна. Бусад төрлийн ажилд оролцох оролцоо 0.7-15.7 пунктээр тус тус буурчээ.

Азийн сангийн нөхөн сэргээлтийн төсөл дуусч орон нутгаас нөхөн сэргээлтэнд БУ-ыг оруулдаггүй

Увс, Өмнөговь сум Бичил уурхайчин эрэгтэй

Ажиллах газаргүй болохоор орлогогүй бусдад хандив туслалцаа өгөх бүү хэл хоногийн хоолоо л бодож байна.

Төв, Заамар Бичил уурхайчин эмэгтэй

Хүйсийн ялгаатай байдлаар үзвэл нөхөн сэргээлтээс бусад төрлийн ажилд гишүүдийн оролцоонд төдийлөн ялгаа алга байна. Суурь судалгааны үеэс нөхөн сэргээлт

хийхэд оролцдог эрэгтэйчүүдийн хувь 4.7 пунктээр өссөн бол эмэгтэй гишүүдийн хувь бараг 10 орчим пунктээр буурсан байна. Дэлгэрэнгүйг хүснэгт 4.2-оос харна уу.

Хүснэгт 4.2.

БУБ-аас зохион байгуулж байгаа ажилд гишүүдийн оролцож буй байдал, хувиар, ажлын төрлөөр, хүйсээр, 2015, 2016 он

	Эрэгтэй		Эмэгтэй	
	2015	2016	2015	2016
Нөхөн сэргээлт хийх	58.2	62.9	61.4	51.5
Спорт урлагийн арга хэмжээ	40.4	33.3	37.7	18.4
Хандив хөрөнгө босгох	48.4	33.3	41.2	25.0
Олборлолт хийх	82.2	86.6	78.9	82.4
Сургалт	4.5	51.5	5.8	58.1
Олон нийтийн нөлөөлөл, олборлолтын газрын тохижилт	1.3	10.7	.8	12.2

БУБ-ын гишүүдийн оролцоо, гарч буй өөрчлөлтийг насны бүлгээр гаргаж хүснэгт 4.3-д харуулав.

55+ насны гишүүдийн оролцоо бүх төрлөөр дээшилсэн байгаа нь бусад бүлгээс ялгаатай байна.

Бусад насны гишүүдийн хувьд олборлолт хийх, сургалтанд оролцох, олон нийтийн нөлөөлөл, олборлолтын газрын тохижилт зэрэг ажилд оролцоо нэмэгдсэн ч хоорондын ялгаа бараг байхгүй байна.

Хүснэгт 4.3.

БУБ-аас зохион байгуулж байгаа ажилд гишүүдийн оролцож буй байдал, хувиар, ажлын төрлөөр, насны бүлгээр, 2015, 2016 он

	Нөхөн сэргээлт хийх		Спорт урлагийн арга хэмжээ		Хандив хөрөнгө босгох		Олборлолт хийх		Сургалт		Олон нийтийн нөлөөллийн ажил	
	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
<25	61.5	53.8	41.0	7.7	30.8	30.8	82.1	84.6	-	53.8	-	7.7
25-34	54.0	56.2	42.0	28.1	47.0	28.9	87.0	84.3	2.9	42.1	1.0	7.4
35-44	56.8	56	36.0	24.6	51.4	28.4	79.3	82.8	4.2	49.3	1.7	11.9
45-54	74.2	62.2	45.2	22.7	48.4	21.8	77.4	80.7	10.1	48.7	1.4	10.3
55+	46.7	68.2	20.0	18.2	26.7	31.8	66.7	77.3	13.3	63.6	-	27.3
Судал-гааны дундаж	59.3	58.4	39.4	24.2	45.9	26.9	81.0	82.4	4.9	47.9	1.2	10.8

Насны бүлгээр ялгаатай байдлыг харвал тухайн ажлын төрлөөр бага зэрэг ялгаа байгаа боловч ерөнхий хандлагаараа 45-54-өөс бусад бүлгийн хувьд төдийлөн ялгаатай биш байна. 45-54 насны гишүүдийн

оролцоо нөхөн сэргээлт хийхэд 12.0 пунктээр, спорт урлагийн ажилд 22.5 пунктээр хандив босгох үйл ажиллагаанд 26.5 пунктээр тус тус буурсан. Дэлгэрэнгүйг хүснэгт 4.3-аас харна уу.

4.3. БУБ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛЖ БУЙ АЖИЛД ГИШҮҮД ОРОЛЦОЖ ЧАДДАГГҮЙ ШАЛТГААН ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ


Энэ бүлэгт гишүүд БУБайгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцож чадахгүй байгаа шалтгаан, түүнд гарч буй өөрчлөлтийг шинжилж үзнэ.

Суурь судалгаагаар БУ-чид үйл ажиллагаанд оролцож чадахгүй байгаа гол шалтгааныг “мэдээллийн хомсдол” байдалтай холбон тайлбарлаж байсан бол харьцуулсан судалгаагаар эдгээр гишүүдийн хувь 10.1 пунктээр буурсан байгаа нь сайшаалтай байна.

Хэдийгээр дээрх шалтгаанаар оролцож чаддаггүй гишүүдийн хувь буурсан ч “Ар гэрийн ажил давхцаад зав гардаггүй” гишүүдийн хувь 44.3 пунктээр, “Өөр газар ажиллаад эзгүй байсан” гишүүдийн хувь 15.2 пунктээр тус тус өссөн байгаа нь үйл ажиллагаанд оролцох хувь гишүүний идэвх, санаачлагыг нэмэгдүүлэх шаардлага байгааг харуулж байна. Дэлгэрэнгүй мэдээллийн зураг 4.4 -өөс харна уу.

Зураг 4.4.

БУБ-аас зохион байгуулж буй ажилд оролцож чаддаггүй шалтгаан, хувиар, 2015, 2016 он




Оролцож чаддаггүй шалтгааны хувьд хүйсийн зарим нэг ялгаа байна. Мэдээлэл байхгүйгээс улмаас оролцож чаддаггүй гэж хариулсан эмэгтэйчүүд 8.3 пунктээр буурсан бол эрэгтэйчүүд 1,6 пунктээр нэмэгджээ. Дүгнэж үзвэл БУБ-ын удирдлагын зүгээс мэдээллийг гишүүдэд

хүргэх ажил сайжирсан ялангуяа эмэгтэйчүүд үйл ажиллагааны талаар мэдээлэл авах нь нэмэгдсэн гэж үзэж болох байна. БУБ-ын гишүүд үйл ажиллагаандаа оролцож чадахгүй байгаа шалтгааныг хүйсийн ялгаатай байдлаар зураг 4.5 д харуулав.

Зураг 4.5.

БУБ-аас зохион байгуулж буй ажилд оролцож чаддаггүй шалтгаан, хувиар, хүйсээр, 2015, 2016 он



БУБ-ын гишүүд үйл ажиллагаандаа оролцож чадахгүй байгаа шалтгаан, гарч буй өөрчлөлтийг нас, боловсролоор нь гаргаж доорх хүснэгт 4.4-д харуулав.

Оролцож чадахгүй байгаа шалтгааныг насны бүлгээр гаргаж үзвэл 25 хүртэлх насны гишүүдийн 83.3 хувь нь “Үйл ажиллагааны талаар мэдээлэл авч чаддаггүй” гэсэн бол бусад бүлгийн хувьд энэ шалтгаанаар оролцож

чаддаггүй гишүүдийн хувь суурь судалгааны үеэс буурчээ.

“Ар гэрийн ажил давхцдаг тул зав гардаггүй” гэх шалтгааны хувьд 25-34 болон 35-44 насны гишүүдийн хувь 51.0 болон 33.9 пунктээр тус тус өссөн ба хүүхдийн сургууль, цэцэрлэг ордог болохоор тэр бүр оролцож чадахгүй байгаа гэж тайлбарлах нь нийтлэг байна.

Хүснэгт 4.4.

БУБ-аас зохион байгуулж буй ажилд оролцож чаддаггүй шалтгаан, хувиар, насны бүлгээр, боловсролоор, 2015, 2016 он

	Ар гэрийн ажил давхцаад зав гардаггүй		Хурал болох үед эзгүй байсан		Мэдээлэл байхгүй	
	2015	2016	2015	2016	2015	2016
<25	18.2	60.0	9.1	20.0	72.7	83.3
25-34	7.8	51.2	11.8	19.5	80.4	71.2
35-44	11.9	62.9	16.9	24.2	71.2	60.3
45-54	10.5	44.4	5.3	36.1	84.2	60.0
55+	21.1	85.7	5.3	28.6	73.7	66.7
Боловсролгүй	-	50.0	-	16.7	100.0	66.7
Бага	14.3	35.7	14.3	21.4	71.4	38.9
Суурь	17.6	64.3	15.7	31.0	66.7	67.3
Бүрэн дунд	11.2	59.4	8.4	26.1	80.4	64.2
Мэргэжлийн анхан шатны	9.1	42.9	9.1	21.4	81.8	81.3
Судалгааны дундаж	12.0	56.3	10.6	25.8	77.4	64.3

Боловсролын түвшинээр нь авч үзвэл “Ар гэрийн ажил давхцдаг тул зав гардаггүй” гэх шалтгаанаар

оролцож чадаагүй суурь, бүрэн дунд боловсролтой гишүүдийн хувь 21.4-50.0 пунктээр нэмэгджээ.


4.4. БҮХ ГИШҮҮДИЙН ХУРАЛ БА ГИШҮҮДИЙН ОРОЛЦОО, ЯЛГААТАЙ БАЙДАЛ, ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ

Судалгаанд хамрагдсан гишүүдийн 23 хувь нь тогтмол 32.1 хувь нь хааяа, 35.4 хувь нь оролцож байгаагүй, 9.5 хувь нь хурал хийдэггүй гэж хариулжээ.

Суурь судалгаатай харьцуулж үзвэл тогтмол оролцдог гишүүдийн хувь 2.7, хааяа оролцдог гишүүдийн хувь 8.2 пунктээр тус тус буурсан байна.

Оролцож байгаагүй гишүүдийн хувь 1.4 пунктээр өсч 9.5 хувь нь өнгөрсөн хугацаанд хурал хийгээгүй гэж хариулжээ. Бүх гишүүдийн хурлын ирц, оролцоо суурь судалгааны үеэс буурсан байна. Түүнчлэн цөөнгүй тооны БУБ хурлаа хийхгүй байгаа нь нөлөөлж байж болох юм.

Зураг 4.6.

Бүх гишүүдийн хуралд оролцож байгаа байдал, хувиар, 2015, 2016 он

Бүх гишүүдийн хурлын оролцоо, гарч буй өөрчлөлтийг хүйсийн ялгаатай байдлаар зураг 4.7-д харуулав.

Зураг 4.7.

Бүх гишүүдийн хуралд оролцож байгаа байдал, хувиар, хүйсээр, 2015, 2016 он

Хэдийгээр тогтмол оролцдог эрэгтэй гишүүдийн хувь 4.5 пунктээр өссөн боловч ерөнхийдөө эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн оролцооны түвшин буурсан байна. Дэлгэрэнгүйг зураг 4.7-оос харна уу.

Бүх гишүүдийн хуралд оролцож чаддаггүй шалтгааныг хувь хүнээс болон хурлын зохион байгуулалт,

удирдлагаас шалтгаалсан гэж ангилж болохоор байна.

Тухайлбал бүх гишүүдийн хурлын ач холбогдол нь гишүүдэд сайн мэдрэгдэхгүй байгаагаас энэ шалтгаанаар хуралд оролцохгүй байгаа гишүүдийн хувь 19.4 пунктээр нэмэгджээ.


Мөн 29.2 хувь нь “ар гэрийн ажлаа зохицуулаад хуралд оролцоогүй” гэж хариулсан нь хувь гишүүний идэвх оролцоотой шууд холбоотой юм.

Харин хурлын талаар зарыг гишүүдэд бүрэн түгээгүйгээс хариулагчдын

55.6 хувь нь “хурлын тухай мэдээгүй” гэсэн нь байгууллагын удирдлагын зүгээс хурлын зарыг сайн түгээгүй, гишүүдийг бүрэн оролцуулах талаар санаачлага гаргаагүйтэй холбоотой юм.

Зураг 4.8.


Бүх гишүүдийн хуралд оролцож чадахгүй байгаа шалтгаан, хувиар, 2015, 2016 он



Онц ач холбогдолтой биш гэж үздэг эрэгтэйчүүдийн 16.2 пунктээр, эмэгтэйчүүд 23.1 пунктээр тус тус өсжээ.

Зураг 4.9.

Бүх гишүүдийн хуралд оролцож чадахгүй байгаа шалтгаан, хувиар, хүйсээр, 2015, 2016 он



4.5. БУБ-ЫН ШИЙДВЭР БА ГИШҮҮДИЙН ОРОЛЦОО, ГАРЧ БҮЙ ӨӨРЧЛӨЛТ


Судалгаанд хамрагдсан гишүүдийн 25.2 хувь нь шийдвэр гаргахад тогтмол, 35.9 хувь нь хааяа оролцдог,

38.9 хувь нь оролцож чаддаггүй гэж хариулжээ. 2015 оны суурь судалгааны үеэс заримдаа оролцдог

гишүүд 6.3 пунктээр буурч оролцож гаргахад гишүүдийн оролцоо буурч чаддаггүй гишүүд 2.0 пунктээр байгааг харуулж байна. Дэлгэрэнгүйг нэмэгдсэн байгаа нь шийдвэр зураг 4.10-аас харна уу.

Зураг 4.10.


БУБ-ын удирдлагын зүгээс гаргаж буй шийдвэрт оролцож буй байдал, хувиар, 2015, 2016 он



Шийдвэр гаргахад огт оролцож эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэж чаддаггүй эрэгтэйчүүдийн хувь 4.3 пунктээр өссөн бол эмэгтэйчүүдийнх байгааг харуулж байна. Дэлгэрэнгүйг 1.9 пунктээр буурсан байгаа нь зураг 4.11-ээс харна уу.

Зураг 4.11.

БУБ-ын удирдлагын зүгээс гаргаж буй шийдвэрт оролцож буй байдал, хувиар, хүйсээр, 2015, 2016 он




Судалгаагаар тухайн БУБ-ын шийдвэр гаргахад хэн голлон оролцож буйг тодорхойлоход БУБ-ын тэргүүн, нөхөрлөлийн ахлагч нар (51.6%)-ын хүрээнд л шийдвэр гаргадаг гэсэн хариулт давамгайлж байлаа.

УЗ тэргүүн хамтарч шийдвэр гаргадаг гэж үзсэн гишүүдийн хувь хамгийн өндөр буюу 18.8 пунктээр нэмэгдсэн нь шийдвэрт УЗ-ийн оролцоо бага боловч нэмэгдэж буйг харуулж байна. Дэлгэрэнгүйг зураг 4.12-ээс харна уу.

Зураг 4.12.

БУБ шийдвэрийг гаргаж буй байдал, хувиар, 2015, 2016 он



Шийдвэр гаргаж буй хэлбэрийн талаар оролцогчдын өгсөн хариултыг хүйсийн ялгаатай байдлаар тодорхойлж үзвэл “гишүүдийн саналыг авч хамтран шийдэлд

хүрдэг” гэж үздэг эмэгтэйчүүд 1.1 пунктээр, УЗ шийдвэр гаргадаг гэж үздэг эмэгтэйчүүд 5.2 пунктээр тус тус буурсан байна.

Хүснэгт 4.5.

БУБ шийдвэрийг гаргаж буй байдал, хувиар, хүйсээр, 2015, 2016 он

	Эрэгтэй		Эмэгтэй	
	2015	2016	2015	2016
Гишүүдийн саналыг авч хамтран шийдэлд хүрдэг	17.9	21.9	22.7	21.6
Гишүүдийн саналыг авдаг ч УЗөвлөл л шийдвэр гаргадаг	13.7	17.3	8.2	11.7
Зөвхөн УЗөвлөл л шийдвэр гаргадаг	15.2	22.5	17.4	12.2
Зөвхөн тэргүүн л шийдвэр гаргадаг	44.4	54.8	46.4	54.5
Удирдах зөвлөл, тэргүүн хамтарч шийдвэр гаргадаг	16.7	35.4	16.4	35.2
Тэргүүн, нөхөрлөлийн ахлагч нар шийдвэр гаргадаг	51.4	55.6	47.8	45.1

Тэргүүн, нөхөрлөлийн ахлагч нар шийдвэр гаргадаг” гэсэн хариулсан эрэгтэйчүүд 4.2 пунктээр өссөн бол эмэгтэйчүүд 2.7 пунктээр буурсан

нь нөхөрлөлийн ахлагч нар (ихэнх нөхөрлөлийн ахлагч эрэгтэй) шийдвэр гаргахад оролцож чаддагтай холбоотой байж болох юм.



ТАВДУГААР БҮЛЭГ: БИЧИЛ УУРХАЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ГИШҮҮДИЙН ЭРХИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, МЭДЛЭГИЙН ТҮВШИН БА ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

БҮЛГИЙН ТОЙМ

БУБ-ын гишүүдийн эрхийн талаарх мэдлэг, эрхийн хэрэгжилтийг хэрхэн үнэлж байгааг суурь судалгааны дүнтэй харьцуулан гарч буй өөрчлөлтийг энэхүү бүлэгт танилцуулав. Хүйс, нас болон боловсролын түвшинээр хэр ялгаатай

байгааг шинжлэн үр дүнг график дүрслэл, тойм статистик болон хамаарлын хүснэгтээр харууллаа. БУ эрхлэхтэй холбоотой өдөр тутмын ажил, амьдралд нь шаардагдаж байдаг дараах эрхийн талаар асуусан болно. Үүнд:

- ▶ Хөдөлмөрлөх эрх/ олборлолтын газар/талаар
- ▶ Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрх
- ▶ Үнэн зөв мэдээллээр хангагдах эрх
- ▶ Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах эрх
- ▶ Нийгмийн халамж үйлчилгээ хүртэх эрх

5.1. ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХ БУЮУ ОЛБОРЛОЛТЫН ГАЗРААР ХАНГАГДАХ ЭРХИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ, ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ

Хөдөлмөрлөх буюу олборлолтын газраар хангагдах эрхийг судалгаанд хамрагдсан гишүүдийн 25.0 хувь нь сайн мэднэ, 44.3 хувь нь ерөнхийд нь л мэднэ, 19.6 хувь нь сонссоноос цаашгүй, 11.1 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.


Гарсан үр дүнг суурь судалгаатай харьцуулсан Зураг 5.1-ээс харахад хөдөлмөрлөх эрхийн талаарх сайн мэддэг гишүүдийн хувь 4.1 пунктээр, ерөнхийд нь мэддэг гишүүдийн хувь 9 пунктээр тус тус нэмэгдэж мэдэхгүй

гэж хариулсан гишүүдийн хувь 12.2 пунктээр буурсан байна.

Суурь судалгаанаас хойшх хугацаанд гишүүдийн хөдөлмөрлөх эрхийн талаарх мэдлэгийн түвшин дээшилсэн гэж дүгнэж болохоор байна. Тайлангийн 3-р бүлэгт дурьдагдсанаар хөдөлмөрлөх эрхээ хамгаалах зорилгоор холбогдох байгууллагад гаргасан албан хүсэлтийн тоо суурь судалгааны үеэс өссөн нь энэхүү дүгнэлтийг баталгаажуулж байгаа юм.

Зураг 5.1.


Хөдөлмөрлөх /олборлолтын газар/ эрхийн талаарх гишүүдийн мэдлэг, хувиар, 2015, 2016 он



Хөдөлмөрлөх эрхийн талаарх мэдлэгийн түвшиний өөрчлөлтийг хүйсээр гаргаж Зураг 5.2-т харуулав.

Зураг 5.2.

Хөдөлмөрлөх /олборлолтын газар/ эрхийн талаарх гишүүдийн мэдлэг, хувиар, хүйсээр, 2015, 2016 он



Зургаас харахад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд эрхийн талаарх мэдлэгийн түвшин 2016 онд сайжирсан төлөв ажиглагдаж байна. Эрэгтэйчүүдийн хувьд сайн мэддэг болон ерөнхийдөө мэддэг гишүүдийн хувь 5.5 болон 6.5 пунктээр,

эмэгтэйчүүдийн хувьд 1.8 болон 13.1 пунктээр тус тус нэмэгдсэн байна. Түүнчлэн, эрхийн талаар сайн мэддэг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувийн зөрүү 2015 онд 1.0 байсан бол 2016 онд 4.7 болж нэмэгджээ.

Хүснэгт 5.1.

Хөдөлмөрлөх /олборлолтын газар/ эрхийн талаарх гишүүдийн мэдлэг, хувиар, насны бүлэг, боловсролоор, 2015, 2016 он

	Сайн мэднэ		Ерөнхийд нь мэднэ		Сонссоноос цаашгүй		Мэдэхгүй	
	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
<25	22	22.2	22	61.1	25.4	11.1	30.5	5.6
25-34	17.8	29	40.1	38.9	19.7	22.8	22.4	9.3
35-44	24.4	27	36	48	20.9	16.8	18.6	8.2
45-54	18.6	20.6	34.7	41.9	21.2	21.9	25.4	15.5
55+	22.9	13.8	34.3	51.7	11.4	13.8	31.4	20.7
Боловсролгүй	18.2	23.7	27.3	55.3	27.3	13.2	27.3	7.9
Бага	16.7	30.4	37.9	47.8	25.8	17.4	19.7	4.3
Суурь	22.7	20.1	34.5	46.5	16.8	25.8	26.1	7.5
Бүрэн дунд	20.7	25.5	37.8	42.7	21.5	17.2	20	14.6
Мэргэжлийн анхан шатны	21.4	34	17.9	34	25	20	35.7	12
Судалгааны дундаж	20.9	25	35.3	44.3	20.5	19.6	23.3	11.1

Хүснэгт 5.1-ээс харахад гишүүдийн мэдлэг ерөнхийдөө дээшилсэн ч, насны бүлгээс хамаараад харилцан адилгүй хэв маягтай байна. Тухайлбал, ерөнхийдөө мэддэг гишүүдийн хувь судалгааны дунджаар 9.0 пунктээр нэмэгдсэн байхад 25 хүртлэх насны залуучуудын хувьд 39 пунктээр нэмэгдсэн байна. Мөн энэ насны мэдэхгүй гэж хариулсан залуучуудын 30.5-аас 5.6 хувь хүртэл буурсан. Харин сайн мэднэ гэж хариулсан

25-34 насны залуучууд хамгийн өндөр өсөлттэй буюу 11.0 пунктээр нэмэгдсэн нь дундаж өсөлтөөс даруй 2.7 дахин өндөр байна.

Боловсролын түвшинээр нь авч үзвэл суурь боловсролтой хариулагчдаас бусад гишүүдийн энэ эрхийн талаарх мэдлэг дээшилсэн байна. Суурь боловсролтой сайн мэддэг гишүүдийн хувь 1.6 пунктээр буурч сонссоноос цаашгүй гэж хариулсан нь 9.0 пунктээр нэмэгджээ.


5.2. Хөдөлмөрлөх эрх буюу олборлолтын газраар хангагдах эрхийн хэрэгжилтийн үнэлгээ, гарч буй өөрчлөлт

Хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд гарсан өөрчлөлтийг тодорхойлохдоо сайн болон ерөнхийд нь л мэддэг гишүүдийн үнэлгээг авсан. (Энэхүү эрхийн талаар сонссоноос цаашгүй болон огт мэдэхгүй хүмүүс хэрэгжилтийн талаарх үнэлгээнд

оролцоогүй болно.) Судалгаанд хамрагдаж хөдөлмөрлөх эрхийн талаар зохих хэмжээний мэдлэгтэй гэсэн гишүүдийн 19.6 хувь нь сайн хэрэгждэг, 50.3 хувь нь ерөнхийдөө хэрэгждэг, 30.2 хувь нь огт хэрэгждэггүй гэж үнэлсэн байна.

Зураг 5.3.

Хөдөлмөрлөх /олборлолтын газар/ эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал, хувиар, 2015, 2016 он



Хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн талаарх үнэлгээг 2015 оны суурь судалгааны үр дүнтэй харьцуулж үзвэл сайн хэрэгждэг гэж үнэлсэн гишүүдийн хувь 4.0 пунктээр өссөн байна. Харин ерөнхийдөө

хэрэгждэг гэсэн нь гишүүдийн хувь 9.5 пунктээр буурч огт хэрэгждэггүй гэсэн гишүүдийн хувь 5.6 пунктээр нэмэгджээ. Олборлолтын газар байхгүй, УУК-тай гэрээ байгуулж чадаагүй зэрэг хүчин зүйлээс

шалтгаалж хэрэгжилтийн үнэлгээ буурах хандлагатай болсон байна. Дэлгэрэнгүйг зураг 5.3-аас харна уу.


Хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн үнэлгээг оролцогчдын хүйсээр авч үзвэл төдийлөн их биш ялгаатай байна. Тодруулбал эрэгтэйчүүдийн хувьд сайн болон огт хэрэгждэггүй гэсэн хариулт нь 1.8 болон 2.4 хувиар, эмэгтэйчүүдийн хувьд ерөнхийдөө л

хэрэгждэг гэсэн хариулт нь 4.2 хувиар тус тус өндөр байна.

Гэвч эмэгтэйчүүдийн хувьд ерөнхий үнэлгээ буурах хандлагатай байна. Тодруулбал сайн хэрэгждэг гэсэн эмэгтэйчүүдийн хувь дөнгөж 1 пунктээр өссөн бол ерөнхийдөө хэрэгждэг 10.4 пунктээр буурч, огт хэрэгждэггүй гэж үздэг гишүүдийн хувь 9.3 пунктээр нэмэгджээ.

Зураг 5.4.

Хөдөлмөрлөх /олборлолтын газар/ эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал, хувиар, хүйсээр, 2015, 2016 он



Зургаас харахад хөдөлмөрлөх эрх сайн хэрэгждэг гэж үздэг эрэгтэйчүүдийн хувьд 5.9 пунктээр өссөн бол ерөнхийдөө л хэрэгждэг гэсэн гишүүдийн хувь 9.1 пунктээр буурсан байна. Огт хэрэгждэггүй гэж хариулсан гишүүдийн хувь 3.3 пунктээр буурсан байна. Дүгнэж үзвэл энэ эрхийн хэрэгжилтийн талаарх эрэгтэй гишүүдийн үнэлгээ суурь судалгааны үеэс төдийлөн өөрчлөгдөөгүй байна.

Эмэгтэйчүүдийн хувьд хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийг сайн гэж үздэг гишүүдийн хувь 1.0 пунктээр өссөнч ерөнхийдөө л хэрэгждэг гэсэн гишүүдийн хувь 10 пунктээр буурсан байна. Огт хэрэгждэггүй гэж хариулсан эмэгтэй гишүүдийн хувь 9.3 пунктээр өссөн байна. Дүгнэж үзвэл энэ эрхийн хэрэгжилтийн талаарх эмэгтэй гишүүдийн үнэлгээ суурь судалгааны үеэс буурсан байна.

Хүснэгт 5.2.

Хөдөлмөрлөх /олборлолтын газар/ эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал, хувиар, насны бүлгээр, боловсролоор, 2015, 2016 он

	Сайн хэрэгждэг		Ерөнхийдөө хэрэгждэг		Огт хэрэгждэггүй	
	2015	2016	2015	2016	2015	2016
<25	26.9	23.1	61.5	53.8	11.5	23.1
25-34	12.5	16.5	62.5	57.8	25	25.7
35-44	12.5	22.7	58.7	45.4	28.8	31.9
45-54	22.2	19.8	60.3	46.9	17.5	33.3
55+	10	10.5	50	57.9	40	31.6
Боловсролгүй	0	13.8	100	41.4	0	44.8
Бага	13.9	5.7	63.9	62.9	22.2	31.4
Суурь	17.6	18.4	50	52.4	32.4	29.1
Бүрэн дунд	16.1	23	60.2	50	23.6	27
Мэргэжлийн анхан шатны	0	24.2	63.6	39.4	36.4	36.4
Суурь судалгааны дундаж	15.6	19.6	59.8	50.3	24.6	30.2

Хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийг насны бүлгээр авч үзвэл 25 хүртэлх болон 45-54 насны гишүүдийн сайн хэрэгждэг гэж хариулсан 3.8 болон 2.4 пунктээр, ерөнхийдөө хэрэгждэг гэж үздэг гишүүдийн тоо мөн 7.7 болон 13.4 пунктээр буурч, огт хэрэгждэггүй гэж үздэг гишүүдийн хувь 11.6 болон 15.8 пунктээр өссөнөөс харахад энэ бүлгийн гишүүдийн хувьд хэрэгжилтийг буурч байгаа гэж үздэг байна. Бусад насны бүлгийн хувьд төдийлөн ялгаа байхгүй байна.

Боловсролын түвшинөөр нь авч үзвэл боловсролгүй болон бага боловсролтой гишүүдийн үнэлгээнд

нилээдгүй өөрчлөлт гарсан байна. Тодруулбал ерөнхийдөө хэрэгждэг гэж үздэг боловсролгүй гишүүд 58.6 хувиар буурсан байхад огт хэрэгждэггүй гэж хариулсан хувь 44.8 пунктээр өсжээ.

Бага боловсролтой хариулагчдын хувьд сайн хэрэгждэг гэж үздэг гишүүдийн хувь 8.2 пунктээр, ерөнхийдөө хэрэгждэг гэж үздэг гишүүдийн хувь 1.0 пунктээр тус тус буурч огт хэрэгждэггүй гэж хариулсан хувь 9.2 пунктээр өсжээ. Үүнээс харахад энэ 2 бүлгийн хувьд хэрэгжилт муу байгаа гэж үздэг байна.

5.3. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ ОРЧИНД АЖИЛЛАХ ЭРХИЙН ТАЛААРХ МЭДЛЭГИЙН ТҮВШИН ГАРЧ БҮЙ ӨӨРЧЛӨЛТ

Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн талаар судалгаанд хамрагдсан гишүүдийн 34.8 хувь нь сайн мэднэ, 37.0 хувь нь ерөнхийд нь л мэднэ, 20.5 хувь нь сонссоноос

цаашгүй, 7.7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.


Суурь судалгааны үеэс Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн талаарх сайн мэддэг гишүүдийн хувь

7.7 пунктээр ерөнхийд нь мэддэг гишүүдийн хувь 1.1 пунктээр тус тус буурсан байна. Сонссоноос цаашгүй гэж хариулсан гишүүдийн хувь 12.3 пунктээр өссөн бол мэдэхгүй гэж

хариулсан гишүүдийн хувь нь 3.5 пунктээр буурсан байна. Ерөнхийд нь дүгнэж үзвэл мэдлэгийн түвшин буурсан байна.

Зураг 5.5.

Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн талаарх гишүүдийн мэдлэг, хувиар, 2015, 2016 он



Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн талаар мэдлэгийн түвшиний өөрчлөлтийг хариулагчдын

хүйсээр ангилан хандлагын шинжилгээний аргыг ашиглаж гаргасныг хүснэгт 5.3-д харуулав.

Хүснэгт 5.3.

Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн талаарх гишүүдийн мэдлэг, хувиар, хүйсээр, 2015, 2016 он

	Сайн мэднэ		Ерөнхийд нь мэднэ		Сонссоноос цаашгүй		Мэдэхгүй	
	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
Эрэгтэй	43.2	34.0	38.3	36.0	7.9	21.0	10.6	8.9
Эмэгтэй	41.5	36.2	37.7	38.5	8.7	19.7	12.1	5.6

Хүйсийн хувьд эрхийн талаарх мэдлэгийн түвшин нилээд ялгаа байна. Энэ эрхийн талаар сайн мэддэг эрэгтэйчүүдийн хувь 9.2 пунктээр, ерөнхийд нь мэддэг хувь

нь 2.3 пунктээр буурч Сонссоноос цаашгүй гишүүдийн хувь 13.1 пунктээр нэмэгджээ. Мэдлэгийн түвшин ерөнхийдөө буурсан гэж дүгнэж байна.

2015 суурь судалгаагаар эмэгтэйчүүдийн хувьд эрхийн талаар сайн мэднэ гэж хариулсан гишүүдийн хувь хамгийн өндөр буюу 41.5 хувь байсан бол 4.7 пунктээр буурсан байна. Хариулагчдын хүйсээр ангилан хийсэн дэлгэрэнгүй шинжилгээг хүснэгт 5.3-аас харна уу. Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн талаар мэдлэгийн түвшиний өөрчлөлтийг насны бүлгээр гаргасныг доор харуулав. 25-34 болон 45-54 насны бүлгийн

хувьд энэ эрхийн талаар сайн мэддэг гишүүдийн хувь 2.5 болон 6.3 пунктээр, ерөнхийд нь л мэддэг гишүүдийн хувь 7.6 болон 5.2 пунктээр тус тус буурч, сонссоноос цаашгүй гишүүд 16.3 болон 16.2 пунктээр нэмэгдсэнээс харахад энэ 2 бүлгийн гишүүдийн мэдлэгийн түвшин буурсан байна. Бусад насны бүлгийн хувьд өөрчлөлтийн хувь харьцангуй бага байна. Насны бүлгээр хийсэн дэлгэрэнгүй шинжилгээг хүснэгт 5.4-аас харна уу.

Хүснэгт 5.4.

Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн талаарх гишүүдийн мэдлэг, хувиар, хүйсээр, насны бүлгээр, боловсролоор, 2015, 2016 он

	Сайн мэднэ		Ерөнхийд нь мэднэ		Сонссоноос цаашгүй		Мэдэхгүй	
	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
<25	49.2	22.2	27.1	38.9	11.9	33.3	11.9	5.6
25-34	40.8	38.3	43.4	35.8	5.9	22.2	9.9	3.7
35-44	41.9	33.2	38.4	40.8	11.6	18.9	8.1	7.1
45-54	39.8	33.5	38.1	32.9	5.1	21.3	16.9	12.3
55+	51.4	41.4	31.4	37.9	5.7	10.3	11.4	10.3
Боловсролгүй	18.2	44.7	54.5	39.5	18.2	13.2	9.1	2.6
Бага	47	13	33.3	50	9.1	37	10.6	-
Суурь	44.5	35.2	34.5	34	7.6	19.5	13.4	11.3
Бүрэн дунд	42.5	37.1	41.8	36.3	7.3	18.7	8.4	7.9
Мэргэжлийн анхан шатны	35.7	34	28.6	36	10.7	24	25	6.0
Судалгааны дундаж	42.5	34.8	38.1	37	8.2	20.5	11.2	7.7

5.4. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ ОРЧИНД АЖИЛЛАХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ, ГАРЧ БҮЙ ӨӨРЧЛӨЛТ

Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн хэрэгжилтэд гарсан өөрчлөлтийг сайн болон ерөнхийд нь л мэддэг гишүүдийн үнэлгээгээр тодорхойлсон. (Энэхүү эрхийн талаар сонссоноос цаашгүй болон огт мэдэхгүй гишүүд хэрэгжилтийн талаарх үнэлгээнд ороогүй болно.)


Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй гишүүдийн 25.4 хувь нь сайн хэрэгждэг, 66.4 хувь нь ерөнхийдөө л хэрэгждэг, 8.2 хувь нь огт хэрэгждэггүй гэж үнэлсэн байна. 2015 оны суурь судалгаатай харьцуулж үзвэл сайн хэрэгждэг

гэж үздэг хариулагчдын хувь нь 1.8 пунктээр өссөн боловч ерөнхийдөө хэрэгждэг гэж 0.5 пунктээр буурчээ. Дүгнэж үзвэл хөдөлмөрийн аюулгүй

орчинд ажиллах эрхийн хэрэгжилт төдийлөн өөрчлөгдөөгүй хэлж болох байна.

Зураг 5.6.

Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал, хувиар, 2015, 2016 он



Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн хэрэгжилтийн талаарх гишүүдийн үнэлгээ гарч буй өөрчлөлтийг хүйсээр ангилан гаргасныг доор харуулав.

Хүснэгт 5.5.

Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал, хувиар, хүйсээр, 2015, 2016 он

	Сайн хэрэгждэг		Ерөнхийдөө хэрэгждэг		Огт хэрэгждэггүй	
	2015	2016	2015	2016	2015	2016
Эрэгтэй	22.8	26.3	67.5	68.7	9.7	4.9
Эмэгтэй	25.0	23.9	65.9	62.9	9.1	13.2

Эрхийн хэрэгжилтийг хүйсийн хувьд нилээд ялгаатай үнэлжээ. Энэ эрхийг сайн хэрэгждэг гэж үздэг эрэгтэйчүүдийн хувь 3.5 пунктээр, ерөнхийдөө хэрэгждэг хувь нь 1.2 пунктээр тус тус нэмэгдсэн ба огт хэрэгждэггүй гэж үздэг гишүүдийн хувь 4.8 пунктээр буурчээ. Мэдлэгийн түвшин өссөн гэж дүгнэж байна.

Харин сайн хэрэгждэг гэж үздэг эмэгтэйчүүдийн хувь 1.1 пунктээр, ерөнхийдөө хэрэгждэг хувь нь 3.0 пунктээр доошилж огт хэрэгждэггүй гэж үздэг гишүүдийн хувь 4.1

пунктээр нэмэгджээ. Эмэгтэйчүүдийн мэдлэгийн түвшин буурсан гэж дүгнэж байна. Хариулагчдын хүйсээр ангилан хийсэн дэлгэрэнгүй шинжилгээг хүснэгт 5.5-аас харна уу. Насны бүлгээр авч үзвэл сайн хэрэгждэг гэж үздэг 35-44 насны гишүүдийн хувь 12.1 пунктээр өссөн боловч бусад бүлгийн хувьд 1.9-8.5 пунктээр буурчээ. Насны бүлгээр болон боловсролын түвшинээр хийсэн дэлгэрэнгүй шинжилгээг хүснэгт 5.6-аас харна уу.

Хүснэгт 5.6.

Хөдөлмөрийн аюулгүй орчинд ажиллах эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал, хувиар, хүйсээр, насны бүлгээр, боловсролоор, 2015, 2016 он

	Сайн хэрэгждэг		Ерөнхийдөө хэрэгждэг		Огт хэрэгждэггүй	
	2015	2016	2015	2016	2015	2016
<25	26.7	18.2	60.0	63.6	13.3	18.2
25-34	21.9	20.0	68.0	74.2	10.2	5.8
35-44	19.6	31.7	75.4	60.7	5.1	7.6
45-54	28.3	23.3	56.5	65.0	15.2	11.7
55+	31.0	26.1	65.5	69.6	3.4	4.3
Боловсролгүй	62.5	15.6	37.5	71.9	-	12.5
Бага	18.9	24.1	71.7	69.0	9.4	6.9
Суурь	24.5	29.1	68.1	62.7	7.4	8.2
Бүрэн дунд	22.8	25.5	65.9	65.8	11.2	8.7
Мэргэжлийн анхан шатны	22.2	22.9	72.2	74.3	5.6	2.9
Судалгааны дундаж	23.6	25.4	66.9	66.4	9.5	8.2

5.5. ҮНЭН ЗӨВ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАГДАХ ЭРХИЙН ТАЛААРХ МЭДЛЭГИЙН ТҮВШИН, ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ

Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн талаар судалгаанд хамрагдсан гишүүдийн 15.5 хувь нь сайн мэднэ, 43.8 хувь нь ерөнхийд нь л мэднэ, 25.0 хувь нь сонссоноос цаашгүй, 15.7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.


Гарсан үр дүнг суурь судалгаатай харьцуулсан Зураг 5.7-оос харахад Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн талаарх сайн мэддэг гишүүдийн

хувь 3.5 пунктээр буурч ерөнхийд нь мэддэг гишүүдийн хувь 8.0 пунктээр тус тус өссөн байна. Сонссоноос цаашгүй гэж хариулсан гишүүдийн хувь 5.8 пунктээр нэмэгдэж мэдэхгүй гэж хариулсан гишүүдийн хувь нь 10.2 пунктээр тус тус буурсан байна.

Ерөнхий хандлагаараа гишүүдийн мэдлэгийн түвшинд төдийлөн өөрчлөлт гараагүй байна.

Зураг 5.7.

Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн талаарх гишүүдийн мэдлэг, хувиар, 2015, 2016 он



Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн талаар мэдлэгийн түвшиний өөрчлөлтийг хүйсээр ангилан гаргасныг хүснэгт 5.7-д харуулав. 2015 суурь судалгаагаар ерөнхийд нь л гэж хариулсан эрэгтэйчүүдийн хувь

хамгийн өндөр буюу 36.8 хувь байсан бол 2016 оны судалгаагаар ижил түвшиний хариулт өгсөн гишүүдийн хувь 3.8 пунктээр нэмэгдэж хамгийн өндөр буюу 40.6 хувь болжээ.

Хүснэгт 5.7.

Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн талаарх гишүүдийн мэдлэг, хувиар, хүйсээр, 2015, 2016 он

	Сайн мэднэ		Ерөнхийд нь мэднэ		Сонссоноос цаашгүй		Мэдэхгүй	
	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
Эрэгтэй	17.9%	16.7	36.8%	40.6	18.2%	23.1	27.1%	19.6
Эмэгтэй	20.8%	13.6	34.3%	48.8	20.8%	28.2	24.2%	9.4

2015 суурь судалгаагаар эмэгтэйчүүдийн хувьд эрхийн талаар “Ерөнхийд нь” гэж хариулсан гишүүдийн хувь хамгийн өндөр буюу 34.3 хувь байсан бол 2016 оны судалгаагаар ижил түвшиний хариулт өгсөн гишүүдийн хувь 14.5 пунктээр нэмэгдэж хамгийн өндөр буюу 48.8 хувь болжээ.

Ерөнхийдөө энэ эрхийн талаарх мэдлэгийн түвшин, түүнд гарсан өөрчлөлтөд хүйсийн ялгаатай байдал харагдахгүй байна

Насны бүлгээр хийсэн шинжилгээнээс харахад 35-44 насны бүлгээс бусад нь ерөнхий хандлагатай төстэй бөгөөд энэ бүлгийн гишүүдийн сонссоноос цаашгүй гэж хариулсан хувь нь 1.4 буурсан нь бусад насны бүлгээс ялгаатай байна. Дүгнэж үзвэл бүх насны бүлгийн хувьд ерөнхийдөө л мэддэг гишүүдийн тоо хамгийн өндөр хэвээр байна. Хариулагчдын нас, боловсролоор ангилан хийсэн дэлгэрэнгүй шинжилгээг хүснэгт 5.8-аас харна уу.

Хүснэгт 5.8.

Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн талаарх гишүүдийн мэдлэг, хувиар, хүйсээр, насны бүлгээр, боловсролоор, 2015, 2016 он

	Сайн мэднэ		Ерөнхийд нь мэднэ		Сонссоноос цаашгүй		Мэдэхгүй	
	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
Эрэгтэй	17.9%	16.7	36.8%	40.6	18.2%	23.1	27.1%	19.6
Эмэгтэй	20.8%	13.6	34.3%	48.8	20.8%	28.2	24.2%	9.4
<25	16.9%	11.1	35.6%	44.4	20.3%	33.3	27.1%	11.1
25-34	14.5%	15.4	40.8%	41.4	18.4%	26.5	26.3%	16.7
35-44	22.1%	14.8	32.0%	45.9	24.4%	23	21.5%	16.3
45-54	16.9%	18.1	40.7%	43.9	16.9%	24.5	25.4%	13.5

55+	34.3%	10.3	17.1%	41.4	2.9%	27.6	45.7%	20.7
Боловсролгүй	.0%	18.4	36.4%	50	36.4%	23.7	27.3%	7.9
Бага	18.2%	6.5	25.8%	54.3	24.2%	26.1	31.8%	13
Суурь	19.3%	18.9	33.6%	34.6	18.5%	28.9	28.6%	17.6
Бүрэн дунд	17.8%	14.2	41.8%	45.7	18.2%	23.2	22.2%	16.9
Мэргэжлийн анхан шатны	14.3%	18.0	32.1%	48	21.4%	22	32.1%	12
Судалгааны дундаж	19.0%	15.5	35.8%	43.8	19.2%	25	25.9%	15.7

5.6. ҮНЭН ЗӨВ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАГДАХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ, ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ

Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн хэрэгжилтэд гарсан өөрчлөлтийг сайн болон ерөнхийд нь л мэддэг гишүүдийн үнэлгээгээр тодорхойлсон. (Энэхүү эрхийн талаар сонссоноос цаашгүй болон огт мэдэхгүй хүмүүс хэрэгжилтийн талаарх үнэлгээнд ороогүй болно.)


Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй гэсэн гишүүдийн 18.2

хувь нь сайн хэрэгждэг, 57.3 хувь нь ерөнхийдөө л хэрэгждэг, 24.5 хувь нь огт хэрэгждэггүй гэж үнэлсэн байна.

2015 оны суурь судалгаатай харьцуулж үзвэл сайн хэрэгждэг хувь нь 5.9 пунктээр буурч, ерөнхийдөө хэрэгждэг гэж 1.2 пунктээр нэмэгдэж, огт хэрэгждэггүй гэж үздэг гишүүдийн хувь 4.8 пунктээр өссөн байна. Дүгнэж үзвэл үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн хэрэгжилт буурсан байна.

Зураг 5.8.

Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал, хувиар, 2015, 2016 он



Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн хэрэгжилтийн талаарх гишүүдийн үнэлгээ гарч буй өөрчлөлтийг

хандлагын шинжилгээний аргыг ашиглаж хүйсээр ангилан гаргасныг хүснэгт 5.7-д харуулав.

Хүснэгт 5.9.

Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал, хувиар, хүйсээр, 2015, 2016 он

	Сайн хэрэгждэг		Ерөнхийдөө хэрэгждэг		Огт хэрэгждэггүй	
	2015	2016	2015	2016	2015	2016
Эрэгтэй	22.9%	22.7	59.2%	56.6	17.9%	20.7
Эмэгтэй	26.3%	11.4	51.8%	58.3	21.9%	30.3

Хариулагчдын хүйсийн байдлаар хэрэгжилтийнүнэлгээнийөөрчлөлтийг авч үзвэл эрэгтэйчүүдийн хувьд сайн хэрэгждэг болон ерөнхийдөө хэрэгждэг гэж үздэг гишүүдийн хувь 0.2 болон 2.6 пунктээр тус тус буурч огт хэрэгждэггүй нь 2.8 пунктээр өсжээ. Иймд эрэгтэйчүүдийн хэрэгжилтийн үнэлгээ буурсан гэж дүгнэж болох байна. Эмэгтэйчүүдийн хувьд ерөнхий хандлагатай адилхан байна.

Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн хэрэгжилтийн өөрчлөлтийг хандлагын шинжилгээний аргыг

ашиглаж насны бүлгээр гаргасныг хүснэгт 5.10-д харуулав.

Бүх насны бүлгийн хувьд “ерөнхийдөө л хэрэгждэг” гэж хариулсан гишүүдийн хувь хамгийн өндөр байгаа боловч тухайн насны ангилалын хувьд зарим өөрчлөлтүүд гарсан байна.

Тодруулбал сайн хэрэгждэг гэж үздэг 25 хүртэлх насны залуучуудын хувь 28.7 пунктээр буурч огт хэрэгждэггүй гэж үздэг гишүүд маш огцом буюу 3.1 дахин нэмэгдсэн байна. Насны бүлгээр болон боловсролын түвшинээр хийсэн дэлгэрэнгүй шинжилгээг хүснэгт 5.10-аас харна уу.

Хүснэгт 5.10.

Үнэн зөв мэдээллээр хангагдах эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал, хувиар, хүйсээр, насны бүлгээр, боловсролоор, 2015, 2016 он

	Сайн хэрэгждэг		Ерөнхийдөө хэрэгждэг		Огт хэрэгждэггүй	
	2015	2016	2015	2016	2015	2016
<25	38.7%	10.0	48.4%	50.0	12.9%	40.0
25-34	18.1%	14.4	61.4%	58.9	20.5%	26.7
35-44	23.7%	24.4	63.4%	52.9	12.9%	22.7
45-54	23.5%	16.7	48.5%	61.5	27.9%	21.9
55+	33.3%	6.7	38.9%	60.0	27.8%	33.3
Боловсролгүй	.0%	23.1	75.0%	34.6	25.0%	42.3
Бага	17.2%	14.3	72.4%	42.9	10.3%	42.9
Суурь	31.7%	24.7	44.4%	62.4	23.8%	12.9
Бүрэн дунд	22.6%	15.1	57.9%	57.9	19.5%	27.0
Мэргэжлийн анхан шатны	25.0%	15.6	58.3%	71.9	16.7%	12.5
Судалгааны дундаж	24.2%	18.2	56.3%	57.3	19.5%	24.5



ЗУРГААДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

БҮЛГИЙН ТОЙМ

ТБУТөслийн санхүү, арга зүйн дэмжлэгтэйгээр БУБ-ын гишүүдийн эрхээ шаардах, хамгаалах, нөлөөллийн ажлууд түүнд гарч буй өөрчлөлт, гишүүдийн оролцоо,

эрхийн талаар мэдлэг түүний хэрэгжилтийн үнэлгээний талаарх дүгнэлт цаашид анхаарах асуудлын талаар тодорхойлж бичсэн болно.

6.1 СУДАЛГААНЫ ТОВЧ ДҮГНЭЛТ

➤ Хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэх зорилго бүхий БУБ-ууд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулсаар бичил уурхайчдын байгууллагын чадавхыг бэхжүүлэх, хүний эрхэд суурилсан хандлагыг хэрэгжүүлэх, гишүүдийн оролцооны чадавхыг дээшлүүлэх, эрүүл аюулгүй нөхцөлд бүтээмжтэй,

хариуцлагатай бичил уурхайг эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр зохих ахиц дэвшил гарсан байна.

➤ БУБ-ын удирдлагын санаачлага идэвх сайжирч, гишүүдийг чадавх бэхжүүлэх төрөл бүрийн сургалтанд хамруулах, бичил уурхай эрхлэхтэй холбоотой шинэ

мэдээлэл түүний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлж ирсэн ажлын үр дүнд гишүүдийн эрхийг хамгаалах, УУК, иргэд малчид олон нийтийн хандлага, хамтын ажиллагаа дээшлүүлэхэд зохих эерэг өөрчлөлтүүд гарсан байна.

- Түүнчлэн БУБ-уудаас байгаль орчинд ээлтэй олборлолт, нөхөн сэргээлт хийх, хөдөлмөрийн аюулгүй байдал хангах талаар анхаарч ажилласнаар зарим үр дүнд хүрч байна. Тухайлбал нийт гишүүдийн 76.6 хувь нь өөрийн олборлолт хийсэн газраа хямд зардлаар нөхөн сэргээх хийх аргачлалын дагуу тогтмол нөхөн сэргээдэг байна.
- БУБ-ын удирдлагууд гишүүдийнхээ эрхийг хамгаалах зорилгоор холбогдох байгууллага, албан тушаалтанд хүсэлтээ албан ёсоор бичгээр илэрхийлэх, баримтжуулах чадвар суурь судалгааны үетэй харьцуулахад нэмэгдсэн байна. Бичил уурхайн байгууллагаас гишүүдээ төлөөлж эрхээ хамгаалах, хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилгоор нийт 107 хүсэлтийг байгууллага, албан тушаалтанд албан ёсоор бичгээр гаргасан байна.
- Эрхээ шаардах, хангах зорилгоор гаргасан албан хүсэлтийн тоо нэмэгдсэн байна. 2015 оны суурь судалгааны үр дүнтэй харьцуулж үзвэл орон нутгийн захиргаандаа гаргаж байсан хүсэлт 13.8 нэгжээр, БУБ-ынхаа удирдлагад гаргаж байсан хүсэлт 11.2 нэгжээр, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй УУК-д гаргасан хүсэлт 14.6 нэгжээр тус тус нэмэгдсэн байна.
- Эрхээ шаардах, хамгаалах үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн

оролцоо нэмэгдсэн байна. Тодруулбал орон нутгийн удирдлагад хүсэлт гаргасан эмэгтэйчүүд хувь 11.7 хувиар, УУК-д хандан хамтран ажиллах хүсэлт гаргасан эмэгтэйчүүд 13.7 хувиар тус тус нэмэгджээ.

- Судалгааны үр дүнгээс харахад БУБ-аас хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд гишүүдийн оролцоо нэмэгдэж байна. Суурь судалгааны дүнтэй харьцуулж үзвэл оролцож чаддаггүй байсан гишүүдийн хувь 8.8 нэгжээр буурч тогтмол оролцож чаддаг гишүүдийн хувь 2.2 нэгжээр өссөн нь гишүүдийн оролцоо, сонирхол дээшилж байгааг харуулж байна.
- БУБ-аас гаргаж буй шийдвэрт гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх шаардлага байсаар байна. Тодруулбал бүх гишүүдийн хуралд тогтмол болон хааяа оролцдог гишүүдийн хувь суурь судалгааны үеэс 2.7 болон 8.2 пунктээр тус тус буурсан байна.
- БУБ-ын гишүүдийн эрхийн талаар мэдлэгийн түвшин сайжирч байгаа боловч тэдгээрийн хэрэгжилт хангалтгүй байгаа гэж үздэг байна. Тодруулбал хөдөлмөрлөх эрхийн талаарх сайн мэддэг гишүүдийн хувь суурь судалгааны үеэс 4.1 нэгжээр нэмэгдэж, мэдэхгүй гишүүдийн хувь 12.2 нэгжээр буурсан байна. Гэвч энэхүү эрхийн хэрэгжилтийг судалгаанд хамрагдаж гишүүдийн 30.2 хувь нь огт хэрэгждэггүй гэж үнэлсэн байна. Олборлолтын газар байхгүй, УУК-тай гэрээ байгуулж чадаагүй зэрэг хүчин зүйлээс шалтгаалж хэрэгжилтийн үнэлгээ буурах хандлагатай болсон байна.

6.2 СУДАЛГААНЫ ТОВЧ ЗӨВЛӨМЖ

Цаашид хариуцлагатай бичил уурхайн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хүний эрх, хүйсийн тэгш байдлыг хангах; бичил уурхайгаар олборлох газрын асуудлыг шийдвэрлэх, өөр бизнест шилжүүлэх, БУБ-уудаас орон нутаг, УУК, иргэд малчидтай хамтран ажиллах, олон нийтийн ойлголтыг хандлагыг өөрчлөх, бичил уурхайчдыг бүртгэлжүүлэн

албажуулах зэрэг нь Хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэх тулгамдсан асуудлууд болж байна.

Хариуцлагатай бичил уурхайг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлан ойлгуулах, албан ёсоор мэдээлдэг тогтолцоог бий болгоход Бичил уурхайчдын БУБ-ууд, нөхөрлөл, МБУНДХ, бичил уурхайчдын оролцоо онцгой чухал байна.

6.1.2. БУБ-уудын зохион байгуулалт, дотоод ажлыг сайжруулах талаар

- 2017 оныг БУБ-ын зохион байгуулалт, дотоод ажлын эмх цэгцгийг сайжруулах, гишүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллах жил болгон зарлах
- “БУБ-ын удирдлагад зориулсан гарын авлага”-ын дагуу дотоод ажилтай холбоотой баримт бичгийг цэгцлэх, шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийх ажлыг 2017 оны эхний хагас жилд багтаан хийх
- Гишүүн ТББ-ууд өөрсдийн гишүүдийн шинэчилсэн бүртгэлийг гаргаж гишүүдэд шаардагдах чадавхын болон ур чадварын сургалтын хэрэгцээг байнга тодорхойлж холбогдох газруудад хүргүүлж байх
- ТББ-аас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа дүрмэнд заасан хугацаандаа тайлагнаж занших
- 2017 онд БУБ бүр гишүүдийн

боломж, нөөцөд тулгуурлан байгууллагын санхүүг бэхжүүлэх зорилготой бодит ажил санаачлан хэрэгжүүлж олсон орлогыг байгууллагын дансанд төвлөрүүлэх

- Орон нутгийн захиргаа, төрийн төв байгууллага, албан тушаалтанд гаргаж буй хүсэлтээ албан ёсоор бичгээр гаргаж баримтжуулж байх шаардлагатай байна.
- БУБ-ын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, орон нутгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг олон нийтэд сурталчлах, зохион байгуулалтанд орж, хууль журмын дагуу албан ёсоор үйл ажиллагаа явуулахын төлөө идэвх санаачлагатай, нийгмийн болон байгаль орчны хариуцлагатай ажиллах чадавхтай гэдгээ орон нутгийн захиргаа, иргэд болон УУК-дад ойлгуулах, сурталчлах ажлыг нэмэгдүүлэх, 2017 оны төлөвлөгөөндөө тодорхой ажил тусган хэрэгжүүлэх

6.2.2. МБУНДХ-ны оролцоог нэмэгдүүлэх

- Бүс хариуцсан Удирдах гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх замаар гишүүн БУБ-уудад үзүүлэх үйлчилгээ ялангуяа орон нутгийн болон төрийн төв байгууллагатай холбох, зуучлах талаар санаачлага гарган ажиллах
- МБУНДХолбооны үйл ажиллагааг орон нутагт, гишүүдэд тайлагнах, ажлын тайланг тогтмол хугацаанд гишүүдэд хэвлэмэл хэлбэрээр хүргүүлж занших
- МБУНДХолбооноос гишүүн БУБ-уудын гишүүдээс сургалтын хэрэгцээг тодорхойлох түргэвчилсэн үнэлгээг хийж сургалтын чиглэлүүдийг тодорхойлох
- МБУНДХолбооны сургалтын албаны сургагч багш нарыг давтан сургалтанд хамруулж, сургагч багшийн гарын авлагаар хангах, орон нутагт зохион байгуулж буй сургалтуудад тухайн БУБ-ын удирдах зөвлөлтэй хамтран ажилладаг болж занших
- ТББ-ын гишүүдийг бүртгэлжүүлэх, “Гишүүдийн оролцоог үнэлэх дэвтэр”-ийг гишүүн бүрд нээн өгч хөтлөлтийг тогтмолжуулах талаар анхаарч дэмжин туслах
- Зөвлөх байгууллагуудын хэрэгжүүлсэн зөвлөх үйлчилгээтэй холбоотой гарын авлага материалыг нэгтгэн МБУНДХолбооны сургагч багшийн цогц гарын авлага бэлтгэх
- ХЭҮКболонмэргэшсэнТББ-уудтай хамтран Бичил уурхайчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг тогтмолжуулах, бичил уурхайн бүхий л үйл ажиллагаанд жендерийн мэдрэмжтэй, хүний эрхэд суурилсан хандлага, арга барилаар ажиллах,
- Аймаг/сумдын ЗДТГазрын ажилтнуудад бичил уурхайн хууль, тогтоомжийг сурталчлах, таниулах, түгээн дэлгэрүүлэх, олон нийтийн хандлага, ойлголт мэдлэгийг өөрчлөх зорилготой ТВ нэвтрүүлэг, сонин зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр өгөх мэдээллийг нэмэгдүүлэх
- Бичил уурхайн салбарт осол аюулгүй орчин бүрдүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтран ХАБ-ын сургалт, тэргүүн туршлага судлах уулзалтуудыг тогтмолжуулж заавал дагаж мөрдөх стандарт, гарын авлага, санамж, зөвлөмжөөр байнга хангаж байх
- Зөвлөлдөх болон туршлага солилцох уулзалтанд БУБ-ын жирийн гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх талаар анхаарч жилд 1 удаа төвлөрсөн хэлбэрээр бус жилд 2-оос доошгүй удаа бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж байх
- Бичил уурхайтай холбогдолтой эрх зүйн орчны хэрэгжилтийг орон нутагтаа зохион байгуулах талаар аймаг/сумдын Засаг дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд тусгах талаар холбогдох талуудтай хамтран ажиллах,
- Хууль бус олборлолт явуулж байгаа иргэд, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг таслан зогсоох талаар аймаг/сумдын удирдлага, холбогдох хуулийн байгууллагад БУБ-уудыг төлөөлөн хандах,
- Орон нутгийн санхүүгийн эх үүсвэрээр орхигдсон болон

эвдэрсэн газарт зохион байгуулагдсан нөхөрлөл, БУБ-уудтай хамтран нөхөн сэргээлт хийх талаар бичил уурхай бүхий

аймаг/сумдын удирдлагуудтай хамтран ажиллах,

6.2.3. ТБУТөсөлд

- БУБ-уудын гишүүдэд зориулсан сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааг хийж сургалтын чиглэл, агуулга, сургалтанд хамрагдах гишүүдийг тодорхойлсны үр дүнд үндэслэн чадавх бэхжүүлэх сургалтуудыг зорилтот гишүүдэд зохион байгуулж байх
- БУБ-ын гишүүдэд хариуцлагатай бичил уурхай эрхлэхэд шаардлагатай шинэ мэдээлэл, арга зүй аргачлал хомс байгааг

харгалзан БУБ-ын ажлын арга барил, сайн туршлагыг дэлгэрүүлэх хэвлэмэл материалын тоо, хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх

- БУБ-уудад хэрэгжүүлж буй жижиг төслүүдийн талаарх мэдээллийг БУБ болон гишүүдэд урьдчилан хүргүүлж сонгон шалгаруулт хийхдээ МБУНДХолбооны оролцоог нэмэгдүүлэх.